

**МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН
АЙМАГТ ХОЛБОГДОЛТОЙ ЗААЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2014.02.01

Үе шат	Стратегийн зорилт	Бодлогын баримт бичиг тусгагдсан байдал		Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Үнэлгээ	ЭЗХЯ-ны үнэлгээ	
		ЗГҮАХ	ЭЗНХҮЧ					
4.1. Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого								
1	2007-2015 он	<p>4.1.1. Хүн амын орлогын өсөлтийг хангах замаар ядуурлыг хоёр дахин бууруулна.</p> <p>1. Хүн амын орлогыг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулах - Ядуурлын түвшин /хувь/</p> <p>2. Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдуулан ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг 3 хувиас ихгүй байлгах - Ажилгүйдлийн түвшин /хувь/</p> <p>3. Өрх, хүн ам, амьжиргааны түвшний талаарх аймгийн хэмжээний мэдээллийн сан байгуулна. Ажилгүй, ядуу, нэн ядуу иргэдэд мэргэжил, ажлын дадлага туршлага эзэмшүүлэн, ажлын байртай болгох, хөгжлийн зээл, тусламжид хамруулах зэргээр амьжиргааны эх үүсвэртэй болох, орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх - Өрх, хүн ам, амьжиргааны түвшний талаарх мэдээллийн сан бий болсон байна - Амьжиргааны түвшин нь дээшилсэн айл өрхийн тоо</p> <p>4. Ажлын байр шинээр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн урамшуулал олгох - Эдийн засгийн урамшуулал олгох эрх зүйн акт батлагдан гарсан байна</p>			НХХ	<p>1. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр 8 хөтөлбөр 1 төсөл хэрэгжүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас /ХЭДС/ 594.720,0 төгрөг зарцуулав. Мөн нийгмийн эмзэг бүлгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх аймгийн комисс байгуулан төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор шийдвэрлүүлэх зохион байгуулалтын ажлууд хийгдэв. Өрхийн орлогыг орлуулан тооцох аргачлалаар 2014 оны жилийн эцсийн дүнгээр амжиргааны түвшин доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь өмнөх онд 38 байсан бол 2014 онд 22,4 хувь болж буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>2. Байнгын ажлын байраар 369 хүнийг, ХЭДС, ЖДҮДС, СХС-ийн зээлээр 603 ажлын байр, төсвийн болон ТББ, бусад бүтээн байгуулалтын хүрээнд 628, нийтдээ 1600 ажлын байр бий болсон. Үүнээс байнгын ажлын байр 1490, түр ажлын байр 110 байна. Ажилгүйдэл 2013 онд 4,0 хувьтай байсан бол 2014 онд 4,8 хувь болж нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд нөлөөлж байгаа шалтгааныг дурдахад: - орон нутагт үйлдвэр үйлчилгээ хөгжөөгүй - ажлын байр нэмэгдүүлэх боломж хомс -ажиллах хүчний нөөц ихтэйгээс гадна ажилгүйчүүдийг бүртгэх бүртгэлийн ажил идэвхжсэн зэрэг нь нөлөөлж байна.</p> <p>3. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааны</p>	70%	70%

					дүнгээр аймгийн хэмжээний нийт өрхийн амьжиргааны түвшинг тогтоож, халамж шаардлагатай өрхүүдийг халамж үйлчилгээнүүдэд хамруулан ажиллаж байна. “АДРА”, “Дэлхийн зөн” ОУБ-уудын үйл ажиллагааны хүрээнд ажлын байрыг нэмэгдүүлэн ажиллав. Халамж үйлчилгээний хүрээнд 3500 өрх, “АДРА” ОУБ ын төслийн хүрээнд 600 өрх, “Дэлхийн Зөн” ОУБ-ын төслийн хүрээнд 2000 өрх буюу нийт төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд 6100 өрхийн амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ авч ажилласан. 4. 2013 онд ажил олгогчийн гэрээ хийгдсэн 9 ажил олгогчийн 17 иргэнд ажил олгогчийн урамшуулал олгосон бол, “Тасты булах” ХХК гэх ажил олгогчийн 3 иргэнд цалингийн дэмжлэг олгосон. 2014 онд 18 ажил олгогчийн 24 иргэнд ажил олгогчийг дэмжих арга хэмжээний гэрээ байгуулсан. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 45.113.000 төгрөгийн санхүүжилт хийгдсэн.	100%	
						70	
2	2007-2015 он	4.1.2. Ядуурлыг бууруулахад бүхий л хэвшлийн байгууллага, иргэдийн оролцоог хангасан зохицуулалтыг бий болгож, ядуурлын түвшинг эрчимтэй бууруулна. 2. Ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд зориулсан сан байгуулж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх - Сан байгуулсан шийдвэр гарсан байна - Санд хуримтлуулсан хөрөнгийн хэмжээ 3. Ядуурлыг бууруулах бодлого, хөтөлбөрийг иргэдийн хэрэгцээ, чадавхид тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлэх - Хөтөлбөр батлагдсан шийдвэр - Хэрэгжилтийн тайлан		НХХ	Ядуурлыг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн 120 гаруй байгууллагуудыг нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд туслах, амьжиргааг нь дэмжүүлэх, тулгамдсан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлүүлэх замаар ядуурлыг тодорхой хэмжээгээр бууруулах арга хэмжээ авч ажиллаж байна. 2014 онд Засаг даргын нөөц хөрөнгөөс 10.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг нэн ядуу иргэдэд олгосон. 2. Ядуурлыг бууруулах үйл ажиллагаанд зориулсан сан байгуулагдаж. Тус санд 2014 оны жилийн эцсийн байдлаар 13.0 сая төгрөг хуримтлалтай байна. 3. “Дэлхийн Зөн” ОУБ /ДЗОУБ/-ын санхүүжилтээр орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, “АДРА ОУБ-ын санхүүжилтээр газар тариалангийн чиглэлээр иргэдийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Орон нутгийн Засаг захиргааны зүгээс хөтөлбөрийн орон нутаг дахь тогтвортой байдлыг хангах талаар бүхий л боломж бололцоог бүрдүүлж ажиллаж байна. ДЗОУБ-аас 2014 онд 320 сая төгрөг, “АДРА” ОУБ-аас 280 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийгдсэн.	70%	100%
3	2007-2015 он	4.2.1. Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үндэсний соёлын дэвшилтэт уламжлал, хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололттой хослуулан		НХХ	Боловсрол, Хөдөлмөр эрхлэлт, Эрүүл мэндийн салбарын хүрээнд хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд Гэр бүлийн боловсрол, нөхөн үржихүйн албан болон албан		

		<p>төлөвшүүлнэ.</p> <p>2. Бүх шатны боловсролын хөтөлбөрийн агуулгыг жендэрийн мэдрэмжтэй болгох</p> <ul style="list-style-type: none"> - Жендэрийн мэдрэмжтэй агуулгатай болгосон хөтөлбөрийн хувийн жин <p>4. Удирдах, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Удирдах болон шийдвэр гаргах түвшний албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 			<p>бус сургалтуудыг явуулж шаардлагатай гарын авлага, ном сурах бичиг тараах, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг олон нийтэд сурталчилах стратеги төлөвлөгөөний биелэлтийг орон нутгийн түвшинд ханган ажиллах, Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх талаар төрийн болон ТББ-уудын уялдаа холбоог хангах бодлого барин ажиллаж байна.</p> <p>2. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ хөтөлбөр хэрэгжүүлж ажил мэргэжлийн чиг баримжаа, зөвлөгөө өгөх сургалтанд хамрагдах хүмүүсийг дэмжих бодлого хэрэгжүүлэн ажилласан ба үүнд нийт 2171 иргэн хамрагдсанаар 978 эрэгтэй, 1193 нь эмэгтэй байна. Мөн жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийг казах хэл дээр хөрвүүлэн олон нийтэд тараах, хялбарчилсан гарын авлага бэлдэх, аюулгүй сургууль, гэр бүлийн үнэ цэнийн тухай хэлэлцүүлэг, шилдэг гэр бүл шалгаруулах, бизнес эмэгтэйчүүдийн чуулга уулзалт, зэрэг олон нийтийг хамарсан ажлууд хийгдсэн. Мөн бага насны хүүхэдтэй эцэг эхчүүд болон жирэмсэн эхчүүдийн ажиллах цагийн зохицуулалт хийж байгууллагын дотоод журамд тусгах удирдамж гарган орон нутагтаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p> <p>4. Аймгийн хэмжээнд төрийн албанд ажиллагсадын дунд Захиргааны өндөр албан тушаалтны эмэгтэйчүүдийн эзлэх хувь нь 44,2 хувь, Удирдах албан тушаалтан 13,8 хувь, улс төрийн өндөр албан тушаалтан 14 хувь байгаа ба эрүүл мэндийн салбарт ажиллагсадын 79 хувь, боловсролын салбарт 73,5 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.</p>	90%		
4.3. Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлого								
4	2007-2015 он	<p>4.3.1. Гэр бүлийг хүний аж төрөх таатай орчин болгоход чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлнэ.</p> <p>1. Гэр бүлийг уламжлалт соёл, ёс заншлын өвийг хадгалан хөгжүүлэх орчин болгох</p> <ul style="list-style-type: none"> - Жилд шинээр гэр бүл бологчдын дотор гэрлэлтээ бүртгүүлсэн шинэ гэр бүлийн эзлэх хувь <p>2. Ядууралд орсон болон эмзэг бүлэгт хамрагдаж буй гэр бүлийн онцлогт тохирсон “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г тэдний өөрсдийн оролцоотойгоор боловсруулж, түүнд үндэслэн амьжиргааг дээшлүүлэх ажлыг тасралтгүй</p>			HXX	<p>1. Аймгийн хэмжээнд 2014 онд нийт 972 өрх шинээр гэр бүл болж бүртгүүлсэн ба үүний шинээр гэр бүл болсон нь 946, дахин гэр бүл зохиож бүртгүүлсэн 26 гэр бүл байна. Нийт гэр бүл бологчдыг 100 хувь бүртгэлд хамруулдаг болсон.</p> <p>2. Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний арга зүйн сургалтыг зохион байгуулж, сум орон нутгийн холбогдох 30 төрийн албан хаагч аймгийн төвийн багуудын 415 өрхийн төлөөллүүдийг хамруулав. Мөн өрхийн хөгжлийн төлөвлөгөөний дэвтрийн хөтлөлтийн явцын байдалд хяналт тавьж, үр дүнг нь тооцох ажлуудыг зохион байгуулан ажилласан. Судалгааны үр дүнд</p>	100%	

		<p>хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Өрхийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу амьжиргаа дээшлүүлэх арга хэмжээнд хамрагдсан өрхийн тоо <p>3. Бүтэн өнчин, хаягдмал, гэр бүлээсээ дайжсан, хараа хяналтгүй хүүхдийг гэр бүлд, эсхүл гэр бүлтэй нь дүйцэхүйц халамжийн таатай орчинд өсгөж хүмүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Төвлөрсөн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн тоо - Хүүхдийг асран хамгаалалтад авсан гэр бүлийн тоо <p>4. “Гэр бүл, хүүхдийн цогц хөгжил” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Хөтөлбөр боловсруулсан байна <p>5. Өрх бүр угийн бичгээ хөтөлж, удамшлын доголдол, оюун ухааны хомсдолоос хамгаалах бодлого хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Угийн бичиг хөтөлдөг өрхийн нийт өрхөд эзлэх хувь - Төрөлхийн оюуны хомсдолтой гэж бүртгэгдсэн хүний тоо /10.0 мянган хүн тутамд/ 			<p>эмзэг бүлгийн өрхөд тулгамдаж буй асуудлуудыг холбогдох төрийн болон ТББ-уудын оролцоотойгоор шийдвэрлүүлж, аймгийн төвийн нийгмийн эмзэг бүлгийн 120 өрхийг байгууллагуудад зуучилж, тэдний бэрхшээлийг шийдвэрлүүлэх, дэмжлэг тусалцаа үзүүлэх зэрэг зохион байгуулалтын ажлууд хийгдсэн нь үр дүнгээ өгч байна.</p> <p>3. 16 хүртлэх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж, амьжиргааг дэмжих нөхцөлт тусламж, нөхцөлт мөнгөн тусламжинд нийт 3413 иргэнийг хамруулж 1.268.619.630 төгрөгийг халамжийн сангаас олгосон байна. Аймгийн нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дэргэдэх асрамжийн газарт 3 хүүхдийг асран халамжилж байна. Тус аймагт хаягдмал, гэр бүлээсээ дайжсан, хараа хяналтгүй хүүхэд байхгүй. 226 бүтэн өнчин хүүхэд байгаа бөгөөд бүгд өөрсдийн өвөө эмээгийнхээ асран хамгаалалтанд байна.</p> <p>4. Гэр бүлийн тухай хуулинд өөрчлөлт оруулах асуудал Засгийн газрын түвшинд хэлэлцэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор хөтөлбөр боловсруулах ажлыг хойшлуулаад байгаа ба зарим судалгааны ажлууд бэлтгэл ажлууд хийгдсэн. Халамж үйлчилгээний хэлтсийн дэргэд Гэр бүлд зөвлөгөө өгөх төв, ХГБХХ-ийн дэргэд “Залуучуудын хөгжлийн төв”-ийг тус тус орон нутгийн хөрөнгөөр байгуулсан.</p> <p>5. Аймгийн хэмжээнд нийт өрхийн 90 хувь нь угийн бичиг хөтөлдөг гэсэн судалгаа гарсан. Омгууд өөр өөрсдийн түүх, угийн бичигтэй болоход нь төр засгийн зүгээс дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Тус аймгийн ихэнх казах хүүхдүүд 7 үеэ цээжээр мэддэг онцлогтой юм. Омгууд хоорондоо гэр бүл болохыг хатуу хориглосон ёс заншил, мөн цус ойртолт түүний хор уршгийн талаар шашны байгууллага болон холбогдох төрийн болон ТББ-уудтай хамтран ухуулга сурталчилгаа хийж хамтран ажиллаж байна. Төрөлхийн оюуны хомсдолтой 77 хүн байгаа ба энэ нь нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 1,7 хувийг эзэлж байна.</p>	70%	
					100%		
					50%		
					90%		
5	2007-2015 он	<p>4.3.2 Хүн амын эмзэг бүлгийн хөгжлийг дэмжих хүний эрхэд суурилсан гэр бүл төвтэй төрийн цогц бодлого хэрэгжүүлнэ.</p> <p>1. Хүн амын тодорхой бүлгийн онцлог хэрэгцээнд тохирсон урьдчилан сэргийлэх, хөгжүүлэх,</p>		НХХ	<p>1. Нийгмийн халамжийн хуулийн дагуу зорилтот бүлгүүдийг өөрсдийн хүсэл сонирхлын дагуу бүлгийн зохион байгуулалтанд оруулан 13 бүлэг үүсгэж тэднийг хоршиж ажиллуулахад зориулан 33,0 сая төгрөгийг халамжийн сангаас санхүүжүүлсэн. Сумдын нийгмийн</p>	70%	

		<p>хамгаалах, зуучлах нийгмийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Хүн амд үзүүлэх нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээний стандарт хэм хэмжээ, дүрэм, зааврыг боловсруулан батлуулж, нийгмийн ажилтнуудыг чадавхжуулна <p>2. Өсвөр үе, залуучуудад ардчилсан, эх оронч үзэл, үндэсний уламжлал, хэл соёл, зан заншлыг төлөвшүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Хүн амын бүтцэд гарах өөрчлөлт, насжилтын асуудлыг нийгмийн бодлого, хөтөлбөр, хөгжлийн төлөвлөлтөд тусгах орчныг бүрдүүлэх. <p>3. Хүн амын бүтцэд гарах өөрчлөлт, насжилтын асуудлыг нийгмийн бодлого, хөтөлбөр, хөгжлийн төлөвлөлтөд тусгах орчныг бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Хүн амын насны бүтцийн өөрчлөлт, насжилтын чиг хандлагыг тодорхойлсон насжилтын Үндэсний стратегийг баталж гаргасан байна. <p>4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох таатай орчныг бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин бүрдүүлсэн аймаг, дүүрэг, сум, хороо, байгууллага, аж ахуйн нэгжийн эзлэх хувь 			<p>ажилтнуудыг чадваржуулах сургалтыг шат дараалан зохион байгуулсан. НХҮХ-ийн дэргэд шинээр байгуулагдсан “Гэр бүлд зөвлөгөө өгөх” төвөөр дамжуулан гэр бүлийн хэлэлцүүлэг, Шилдэг гэр бүлүүдийг шалгаруулах зэрэг ажлуудыг холбогдох төрийн болон ТББ-уудтай хамтран зохион байгуулсан.</p> <p>2. Өсвөр үе залуучуудад зориулж аймгийн Засаг даргын санаачлагаар ардчилсан эх оронч үзэл, үндэсний соёл зан заншлыг төлөвшүүлэх сэдвээр чуулга уулзалт мөн Залуу малчдын зөвлөгөөн, Залуучуудын нэгдсэн чуулганыг тус тус зохион байгуулж, гарсан шийдвэрүүдийг тодорхой хэмжээгээр шат дараалан холбогдох байгууллагуудын оролцоотойгоор шийдвэрлүүлэн ажиллаж байна. 2014 онд Байгаль орчныг хамгаалах, амьдарч буй орчноо цэвэрхэн байлгах, Нийгмийн эрүүл мэнд, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, Үндэсний хувцасыг сурталчлах, залуу төрийн албан хаагчдыг чадваржуулах зэрэг 10 гаруй томоохон ажил зохион байгуулагдсан ба энэ үйл ажиллагаанд зориулж төрийн болон төрийн бус байгууллагууд хамтарч 30.0 орчим сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>3. Швейцарын хөгжлийн агентлаг, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам /ХАХНХЯ/-тай хамтран Залуучуудын хөгжлийн төвийг ХГБХХ-ийн дэргэд байгуулж үйл ажиллагааг нь тогтвортой явуулах боломжоор ханган ажиллав. Мөн хүн амын насны бүтэц, дундаж наслалт, насжилтын чиг хандлагыг тодорхойлох судалгааны бааз бий болгож, хүн ам зүйн бодлогын талаар тусган стратеги төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.</p> <p>Аймгийн нийт хүн амын тоо 93.165 болж өссөн ба үүнээс эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 50,04, эмэгтэйчүүдийн хувийн жин 49,96 байгаа нь хүйсийн бүтцийн хувьд тэнцүү байна. Хүн амын 36,1 хувийг /33691/ хүүхэд, 55,7 хувийг /54650/ хөдөлмөрийн насны хүн, 5,2 хувийг /4824/ өндөр настангууд эзэлж байна.</p> <p>4. МУЗГ-аас баталсан тогтоолын дагуу хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг 25-аас дээш ажилтантай байгууллага бүр авч ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр 30 хувиар тооцон төсөвт төлбөр төлдөг журмыг холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлж байна. Аймгийн хэмжээнд 50-иас дээш</p>	<p>90%</p> <p>90%</p> <p>70%</p>	
--	--	---	--	--	--	----------------------------------	--

						ажилтантай 60 байгууллага байгаа ба үүний 31 байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнийг авч ажиллуулж байна. 2013-2014 онд шинэ бүтээн байгуулалтаар бий болсон зам, барилга байгууламжуудаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг шийдвэрлэсэн ажил 80-85 хувьтай биелэгдсэн байна.			
6	2007-2015 он	<p>4.3.3. Эцэг, эх үр хүүхдээ эрүүл, саруул өсгөн бойжуулж, боловсрол хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхийг төрөөс дэмжинэ</p> <p>Төрөлтийг дэмжих замаар хүн амын жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлж, улмаар хүн амаа өсгөх бодлого баримтална</p> <p>1. Эхийн эрүүл мэндийг жирэмслэлтийн эхэн үеэс хамгаалах, ургийн бойжилтыг оношлох, хянах, хүүхдийг нэг нас хүртэлх хугацаанд шаардлагатай тохиолдолд нэмэлт тусгай хоол, хүнсээр үнэ төлбөргүй хангадаг үндэсний жишиг боловсруулан тогтоож хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Жирэмсний эхний 3 сардаа эмнэлгийн хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн хувь - Эхийн эндэгдлийн түвшин /100.000 хүн амд/ - Нярайн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/ <p>4. 0-18 насны дөрөв болон түүнээс дээш хүүхэдтэй өрхийг орон сууцаар хөнгөлөлттэй үнээр хангах бодлого хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - 0-18 насны дөрөв болон түүнээс дээш хүүхэдтэй өрхийг орон сууцаар хөнгөлөлттэй үнээр хангах бодлого хэрэгжүүлэх 		НХХ, ЭМГ, НЭ	<p>1.1. Жирэмсний эхний 3 сардаа эмнэлгийн хяналтад орсон жирэмсэн эмэгтэйчүүд 85.6%-тай.</p> <p>1.2. Эхийн эндэгдэл 1990 онд 13 эх эндэж байсан ба 2010 онд 1, 2011 онд, 2012 онд 3, 2013 онд 4, 2014 онд 1 тохиолдол гарч буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>1.3. Нялхсын эндэгдэл 2013 онд 48 тохиолдол, 2014 онд 66 тохиолдол гарсан. Энэ нь эхчүүдийн цус багадалт, бөөр, савны өвчлөл зэрэг олон хүчин зүйл нөлөөлөхийн зэрэгцээ гарч буй хүүхэд нь жин багатай, суурь өвчин ихтэй төрдөгтэй холбон үзэж байна.</p> <p>4. 0-18 насны дөрөв болон түүнээс дээш хүүхэдтэй өрхийг орон сууцаар хөнгөлөлттэй үнээр хангах бодлого баримтлан ажиллаж байгаа. 2014 онд "Цамбагарав-Өгөөж" ХХК, "Абах" хоршооны барьж гүйцэтгэсэн орон сууцанд тодорхой хэмжээний өрхүүд хөнгөлөлттэй зээлд хамрагдан орсон байгаа.</p>	90%	90%	50%	30%

7	2007-2015 он	<p>4.3.4. Хүүхэд эхээс төрсөн цагаасаа зургаан нас хүртэл гэр бүл, эсхүл түүнтэй дүйцэх орчинд өсөж торних, зөв хүмүүжил, ёс суртахуунтай болох, сургуулийн өмнөх боловсрол олгоход төрөөс онцгой анхаарна.</p> <p>1. Хүүхдийг хөхөөр хооллох, зургаан нас хүртэл нь эрүүл мэндийн тусгай хяналтад байлгах нөхцөл бүрдүүлэх</p> <p>- Дан эхийн хөхөөр хооллодог 0-59 сартай хүүхдийн эзлэх хувь</p> <p>2. Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдийг зургаан нас хүртэл нь насны онцлогт тохирсон эрүүл хоол хүнсээр хөнгөлөлттэй үнээр хангах</p> <p>3. Хүүхдийн бие бялдар, эрүүл мэнд, оюун ухаан, сэтгэцийн зөв хөгжилтэй, үндэсний хэл, сэтгэлгээтэй болгох хүмүүжүүлэхэд эцэг, эх, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын байгууллагын үүргийг өндөржүүлэх.</p>			НХХ, ЭМГ, ХГБХ Г	<p>1. Манай аймагт 0-59 сартай хүүхэд 11507 хүүхэд байгаа бөгөөд эдгээр хүүхдүүдийн 624 хүүхэд дан эхийн хөхөөр хооллодог. Энэ нь 0-59 сартай хүүхдийн 5.42%-ийг эзэлж байна.</p> <p>2. Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхөд олгодог хүнсний талон 398 өрхийн 1246 насанд хүрэгч, 1313 хүүхэд хамрагдаж байна. 2014 онд “Дэлхийн Зөн” ОУБ-ын ОНХХөтөлбөр хэрэгждэг Толбо, Улаанхус сумдын нэн ядуу 50 өрхийн 6 хүртлэх насны хүүхдүүдийг цагаан идээ, үнээний сүү зэрэг эрүүл, илчлэг хоол хүнсээр хангах зорилгоор /1 өрхөд тугалтай 3 үнээ/ 150 тугалтай үнээ өгч бага насны хүүхдүүдийг эрүүл чийрэг өсч хөгжихөд нь тусламж үзүүлсэн. Үүнд 120.0 орчим сая төгрөг зарцуулсан.</p> <p>3. Хүүхдийн бие бялдар, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хүүхдүүдийг чийрэгжүүлэх үүднээс аеробекийн тэмцээнийг ЭМГ, БГ, ХГБХХ, ССАЖГ зэрэг байгууллагууд хамтран аймгийн төвийн бүх сургуулиудад зохион байгуулж, үүнд нийт 201 хүүхэд оролцсон. Мөн хүүхдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулж аймгийн төвд залуучуудын паркийг шинээр ашиглалтанд оруулсан ба үүний үр дүнд хүүхдүүд эрүүл чийрэг, зөв боловсон иргэн болж төлөвших нөхцөл бүрдэхэд дөхөм болсон.</p>	90%	
4.4. Боловсролын хөгжлийн бодлого								

8	2007- 2015 он	<p>4.4.1. Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ.</p> <p>1. Бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none">- Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь- Үүнээс цэцэрлэгийн хамран сургалтын хувь <p>2. Бүх шатны боловсролын байгууллагын суралцагчид болон багшийн хүйсийн харьцааг тэнцвэртэй болгох</p> <ul style="list-style-type: none">- Бага боловсрол эзэмшиж буй охид, хөвгүүдийн тооны харьцаа- Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшиж буй охид, хөвгүүдийн тооны харьцаа- Мэргэжлийн боловсролын сургуулийн эмэгтэй, эрэгтэй суралцагчдын тооны харьцаа- Дээд боловсрол эзэмшиж буй эмэгтэй, эрэгтэй оюутны тооны харьцаа (суурь он - 2008)- Бага ангийн үндсэн багшийн дотор эрэгтэй багшийн эзлэх хувь- Дунд ангийн үндсэн багшийн дотор эрэгтэй багшийн эзлэх хувь <p>3. Боловсрол нөхөн олгоход дэмжлэг үзүүлэх</p> <ul style="list-style-type: none">- Насанд хүрэгчдийн суурь боловсрол эзэмшилтийн хувь- Сургууль завсардагчдаас сургуульдаа буцан орсон хүүхдийн хувь- Сургуулийн гадна байгаа сургуулийн насны хүүхдүүдээс бичиг үсэг, бага, суурь боловсрол нөхөн эзэмшсэн хүүхдийн хувь- Бага, суурь боловсрол нөхөн эзэмшсэн иргэдийн хувь <p>4. Хөдөөгийн малчин өрхийн 0-6 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг нүүдлийн аж байдалд нь тохируулан зохион байгуулах</p> <ul style="list-style-type: none">- Малчин өрхийн 2-5 насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамралтын хувь <p>5. 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах</p> <ul style="list-style-type: none">- 6 настай хүүхдийн сургуульд хамралтын хувь (суурь он-2008) <p>6. Хөвгүүдийн боловсролын түвшинг</p>			<p>НХХ, БГ</p> <p>1.1. Бага насны хүүхдийн СӨБ-д хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлж цэцэрлэгийн хувилбарт сургалтыг гэр цэцэрлэгийн замаар үйл ажиллагаа явуулсан үр дүнд сургуулийн өмнөх боловсролд хамрагдалд 71,8% болсон ба энэ үзүүлэлт 2008 онд 65.3%-тай байсан байна.</p> <p>1.2. Цэцэрлэгийн хамрагдалд 2008 онд 40.3%-тай байсан бол 2014 онд 43,8%-тай байна.</p> <p>2. Суралцагчид болон багшийн хүйсийн харьцааг тэнцвэртэй болгох асуудал маш төвөгтэй бөгөөд бага боловсролд охид 0,49% хөвгүүд 0,51 ба суурь боловсролд охид 0,51% хөвгүүд 0,49%, мэргэжлийн боловсролд 0,38% хөвгүүд 0,62% дээд боловсролд охид 0,53% хөвгүүд 0,47% байна. Бага ангийн үндсэн багшийн дотор эрэгтэй 10,9%, эмэгтэй 89,1%, дунд ангид эрэгтэй 34,1%, эмэгтэй 68,6%-тай байна.</p> <p>3. Насанд хүрэгчдийн суурь боловсрол эзэмшигчдийн хувь 2008 онд 71,3% байсан бол 2014 онд 71,3% байна. Сургууль завсардагчдаас 2008 онд сургуульд буцан орсон хүүхдийн хувь 4,3% байсан бол 2014 оны байдлаар 6,8% байна. Сургуулийн гадна байгаа сургуулийн насны хүүхдүүдээс бичиг үсэг бага суурь боловсрол нөхөн эзэмшсэн хүүхдийн хувь 2008 онд 3,2% 2014 онд 5,6% болон өссөн.</p> <p>4. Малчин өрхийн 2-5 насны хүүхдийг СӨБ-д хамруулахын тулд зуны улирлын чанартай 25 гэр цэцэрлэг ажиллаж, түүнд 520 гаруй хүүхэд хамрагдсан байна. 2008 онд энэ үзүүлэлт 3,1% байсан бол 2014 онд 23,3 болж өссөн.</p> <p>5. Зургаан настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах үүднээс олон талт ажил зохиосон боловч, янз бүрийн нөхцөл байдлаас шалтгаалж үүнтэй холбоотой ажил сайн хэрэгжихгүй байгаа ба 2014 оны байдлаар 71,5% - тай байна.</p> <p>6. Сургуульд эрэгтэй хүүхдийн бүрэн дунд боловсролын хамран сургалт 2008 онд 80,1% байсан бол 2014 оны байдлаар 81,8% болж ахисан.</p> <ul style="list-style-type: none">- 1-5 дугаар ангид суралцагч эрэгтэй хүүхдийн эзлэх хувь 2008 онд 49,5 байсан бол 2014 оны байдлаар 51%	<p>90%</p> <p>70%</p> <p>70%</p> <p>100%</p> <p>70%</p> <p>70%</p>
---	------------------	--	--	--	--	--

		<p>дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Эрэгтэй хүүхдийн бүрэн дунд боловсролын хамран сургалтын хувь (цэвэр жин) - Нэгдүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцсан эрэгтэй хүүхдийн хувь - Эрэгтэй хүүхдийн бага боловсрол эзэмшилтийн хувь - Эрэгтэй хүүхдийн суурь боловсрол эзэмшилтийн хувь <p>7. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тохилог орчинг бүрдүүлж, дотуур байранд суух хүүхдийн тоог 2.1 дахин нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Дотуур байранд хамралтын хувь - Дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо - Дотуур байрны орны тоо <p>8. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын “Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Үдийн цай/хоол хөтөлбөрт хамралтын хувь - Улсын төсвөөс хөтөлбөрт зарцуулсан нийт зардал (тэрбум төг) 			<p>болж ахисан.</p> <ul style="list-style-type: none"> - Эрэгтэй хүүхдийн суурь боловсролын эзэмшилтийн хувь 2008 онд 47,3% байсан бол 2013 онд 49% болж ахисан. <p>7. Малчдын хүүхдээс дотуур байранд нийт 5620 гаруй хүүхэд байна гэсэн тооцоо гарсан бөгөөд эдгээр хүүхдүүдийн 87,1% /2008 онд 84,3%-тай/ буюу 4482 гаруй хүүхэд өөрсдийн хүсэлтээр дотуур байранд хамрагдсан. Дотуур байрны орны тоо 3502 байгаа нь дотуур байр маш их ачаалалтай байна.</p> <p>8. Үдийн цай хөтөлбөр амжилттай үргэлжилж байна. 2013 онд аймгийн хэмжээнд 1 тэрбум 166 сая 19 мянган 700 төгрөг төсөвлөгдөж түүний гүйцэтгэл 1 тэрбум 125 сая 519 мянган 600 төгрөг байсан. 2014 онд 1 тэрбум 31 сая 4 мянган төгрөг төсөвлөгдөж түүний гүйцэтгэлд бүгд 100% зарцуулагдсан.</p>	70%			90%	
9	2007-2015 он	<p>4.4.2. Боловсролын бүх түвшний стандарт, сургалтын хөтөлбөрийг тухайн үеийн суралцагчийн хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.</p> <p>1. Шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан боловсролын стандартын шалгууруудыг нарийвчлан тогтоох</p> <ul style="list-style-type: none"> - Стандартын шалгуур хангасан хөтөлбөрийн хувь <p>4. Боловсролын шинэчлэл-өөрчлөлтийг эхлэн туршиж зүгшрүүлдэг “Туршилтын бааз сургуулиудын лаборатори бүтэц”-ийг буй болгоно. Үүнд: Улаанбаатар хотод 10 хүртэл, аймаг бүрт 2 хүртэл тооны сургуулийг сонгох буюу шинээр байгуулах замаар хамруулж, боловсролын шинэчлэлийн санаачилгыг дэмжих</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөө орон нутагт байршилтай туршилтын бааз, лаборатори сургуулийн тоо <p>5. Бүх нийтийн монгол хэл, бичгийн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, бүх шатны сургуульд эх хэлээ төгс эзэмшиж ашиглах, бичих, илтгэх ур чадварыг хөгжүүлэх нөхцөл боломжийг</p>		НХХ, БГ	<p>Шинжлэх ухаан технологийн ололтод тулгуурлан боловсролын стандартын шалгууруудыг тогтоох ажлыг боловсролын газар сурганы сектортай хамтран хийж Казах, Тува сургуулийн стандартыг тогтоох ажлыг 2014 онд хийж дууссан. Стандартын шалгуур хангасан хөтөлбөр 60,3%-тай байна.</p> <p>4. Аймгийн төвийн ЕБС-ийн 3-р бүрэн дунд сургуульд туршилтийн бааз лаборатори бүтцээр хэвийн, үр дүнтэй ажиллаж байгаа.</p> <p>5. Монгол хэл бичгийн боловсролыг дээшлүүлэх талаар анхаарч сургалтын төлөвлөгөөнд түүний эзлэх хувийг 15,4%-д хүргэсэн. Стандартын хэрэгжилт маш доогуур, амжилт 48% чанар 10%-тай байна.</p> <p>6. Англи хэлийг голлох гадаад хэл болгох эрх зүйн үндэс бүрэн тавигдсан ба заагдах хичээлийн цаг нэмэгдсэн. Англи хэлний анхан шатны боловсролтой иргэдийн эзлэх хувь 2008 онд 33,8%-тай үзүүлэлттэй байсан бол 2014 онд 39,6% болж өссөн.</p>	50%		100%	50%	50%

		<p>нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнд монгол хэл, бичгийн хичээлийн цагийн эзлэх хувь - ЕБС-ийн монгол хэл, бичгийн стандартын хэрэгжилт (сурлагын амжилт) <p>6. 2015 онд багтаан англи хэлийг бүх нийтийн голлох гадаад хэл болгох</p> <ul style="list-style-type: none"> - Англи хэлний анхан шатны боловсролтой иргэдийн эзлэх хувь 							
10	2007-2015 он	<p>4.4.3 Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, энэ чиглэлд хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлнэ</p> <p>1. Багш, удирдах ажилтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинэчлэн сайжруулж, энэ чиглэлд мэргэжлийн төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Жилд мэргэшил дээшлүүлсэн багшийн эзлэх хувь <p>2. Багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны ур чадварыг хөгжүүлж, ажлын чанар, хөдөлмөрийн үр бүтээлийг үнэлэх шалгууруудыг зөв тогтоож, цалин хөлс нэмэгдүүлэх, урамшуулал олгох зэргээр нийгмийн хамгааллыг сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> - Боловсролын салбарын нийт багш нарт удирдлагаар мэргэшсэн боловсролын салбарын ажилтны эзлэх хувь <p>3. Дотооддоо мэргэжил дээшлүүлэх нийт зардлыг 2004 онтой харьцуулан 2007 оноос эхлэн ойролцоогоор 6 дахин нэмэгдүүлж, цаашид жил бүр 10 хувиас доошгүй өсгөх</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэшил дээшлүүлэхэд зарцуулсан нийт зардлын хэмжээ (тэрбум төгрөг) 				<p>1. Багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх ажлыг онцгой анхаарч ажилласан. Давхардсан тоогоор 5150 гаруй багш сургалтанд хамрагдаж 68,5%-д хүрсэн байна. 2008 онд энэ үзүүлэлт 57,7% байсан.</p> <p>2. БШУ-ны сайдын тушаал гарч, багшийн хөдөлмөрийг шинэ эрх зүйн орчинд үнэлэх талаар журам батлагдаж, журмын дагуу үйл ажиллагаа хэрэгжиж байна. Мэргэшсэн боловсролын салбарын ажилтаны эзлэх хувь 38,9% байна.</p> <p>3. Багш нарын мэргэжлийг дээшлүүлэхэд орон нутгийн төсвөөс нийт 10.1 сая төгрөг зарцуулсан.</p>	70%	50%	100%
11		<p>4.4.6 Сургууль төвтэй менежментийг хөгжүүлж, сургалтын байгууллагын бүтэц, хэв шинж, байршлын зураглалыг шинэчлэн зохионо</p> <p>1. Боловсролын салбарын захиргааны болон мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгох</p> <ul style="list-style-type: none"> - Шуурхай, тунгалаг, чадварлаг байдал <p>2. Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургуулийн бүтэц, хэв шинж, хэмжээ, байршлыг оновчтой болгосон цэцэрлэг, сургуулийн зураглалыг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх</p>				<p>1. Боловсролын салбарын захиргаа мэргэжлийн удирдлагыг улам боловсронгуй болгох үүднээс олон төрлийн сургалт семинар зохион байгуулагдаж шинэ хүний нөөцийг дайчлах, зарим сургуулийн захирлыг өөрчлөх, хариуцлага тооцох, ур чадварыг дээшлүүлэх талаар цогц арга хэмжээ авагдаж байна.</p> <p>2. Улсын төсвийн хөрөнгөөр Өлгий сумын 8-р хүүхдийн цэцэрлэгийн 75 хүүхдийн багтаамжтай барилга, Булган сумд мөн адил 75 хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр баригдаж ашиглалтанд орсон.</p>	90%		

		- Бий болгосон зураглал, түүний дагуу байршуулж засварлан, барьсан сургууль, цэцэрлэгийн тоо			Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургууль, цэцэрлэгүүдэд нийт 440.0 сая төгрөгийн их засвар хийгдсэн. Үүнд: - Улаанхус сумын бүрэн дунд сургуульд 140.0 сая төгрөг - Өлгий сумын хүүхдийн 7-р цэцэрлэгт 80.0 сая, 10-р цэцэрлэгт 70.0 сая, 3-р бүрэн дунд сургуульд 150.0 сая төгрөгийн засвар хийгдсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Өлгий сумын 1-р бага сургуулийн спорт заалны барилга 390.0 сая төгрөгийн өртөгтэйгээр барьж ашиглалтанд оруулсан. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сургууль цэцэрлэгүүдэд 370.1 сая төгрөгийн засвар хийгдсэн. Үүнд: - Өлгий сумын 1-р хүүхдийн цэцэрлэгт 18.7 сая, 4-р хүүхдийн цэцэрлэгийн засварын дутуу санхүүжилт 10.0 сая, 1-р бүрэн дунд сургуулийн нийтийн бие засах газар барихад 7.0 сая, 2-р бүрэн дунд сургуулийн хуучин “А” байрны их засварт 47.0 сая, 3-р бүрэн дунд сургуулийн халаалтын засварт 100.0 сая, 4-р бүрэн дунд сургуулийн дээврийн засварт 187.4 сая төгрөг зарцуулсан. -Мөн “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусламжаар Бугат сумын хүүхдийн цэцэрлэгийн барилгад 166.8 сая төгрөгийн их засвар тус тус хийгдсэн.	100%	
--	--	--	--	--	---	------	--

4.5. Эрүүл мэндийн хөгжлийн бодлого

12		4.5.1. Сум, өрхийн эмнэлгийн анхан шатны тусламж хүргэх, шинжилгээ, оношилгоо, эмчилгээ, дархлаажуулалт хийх, шүдний өвчин эмчлэх, БЗДХ, ХДХВ/ДОХ, сүрьеэгээс сэргийлэх, эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах чадамжийг цогц байдлаар хөгжүүлнэ. 1. Эх, нялхасыг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох - Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийн түвшин 1990 онтой харьцуулахад 4 дахин буурсан байна /100.000 амьд төрөлт тутамд/ - Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1990 онтой харьцуулахад 4 дахин буурсан байна /1000 амьд төрөлт тутамд/ - Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/		НХХ, ЭМГ	Эрүүл мэндийн хөгжлийн бодлогыг аймаг, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх зорилгоор, аймгийн эрүүл мэндийн хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг /2011-2015/ боловсруулах ажлын хэсгийг ЭМГ-ын даргын 2010 оны 42 тоот тушаалаар байгуулан ажиллуулж, эмч мэргэжилтнүүдийнхээ мэдлэг болон тэдний саналд тулгуурлан, тухайн үеийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлаа тодорхойлон, ЭМЯ, ЗГХА-ЭМГ-ын бодлого, зөвлөмжийг тусган боловсруулж дунд хугацааны стратеги төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайд, Аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлж байна. Эрүүл мэндийн хөгжлийн бодлогын аймаг, орон нутагтай холбогдолтой дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх талаар тус аймагт дараах үйл ажиллагааны арга хэмжээнүүдийг зохион байгуулсан 1.1. Эхийн эндэгдэл 1990 онд 13 эх эндсэн /4,1 промилтэй байсан 1990 онд эхийн эндэгдлийг 1000	90%	
----	--	--	--	----------	---	-----	--

		<p>2. Шүд эмчлэх, эрхтэн тогтолцооны өвчний оношилгоо, эмчилгээний арга, технологийг сумын түвшинд нэвтрүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Шүд цоорох өвчний тархалтын хувь /5-6 настай хүүхдийн дунд/ <p>3. БЗДХ, ХДХВ/ДОХ, сүрьеэтэй тэмцэх чадвартай болгох</p> <ul style="list-style-type: none"> - 2015 он гэхэд ХДХВ/ДОХ, сүрьеэ өвчний тархалтыг зогсоож, БЗДХ-ыг бууруулж эхэлсэн байна - Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд ХДХВ-ийн тархалт - 15-24 насны залуучуудын дундах ХДХВ-ын халдварын тархалт - Сүрьеэ өвчний тархалт /100.000 хүн амд/ - Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /100.000 хүн амд/ - Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт <p>4. Малчдад нүүдлийн өрхийн эмнэлгээр үйлчлэх тогтолцоог бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Малчдад явуулын амбулаторийн тусламж, үйлчилгээг үзүүлэх заавар, журам батлагдаж, үйл ажиллагаа явагдаж эхэлсэн байна 			<p>амьд төрөлтөнд харьцуулдаг байсан/ ба 2010 онд 1 тохиолдол, 2011 онд 2 тохиолдол, 2012 онд 3 тохиолдол байсан бол 2013 онд 4 тохиолдол, 2014 оны байдлаар 1 тохиолдол гарч 35,9 промилль болж 1990 онтой харьцуулахад харьцангуй буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>1.2. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 онд 77,33 промилль байсан ба 2010 онд 33,1 промилль, 2011 онд 27,3 промилль, 2012 онд 26,5 промилль, 2013 онд 23,9 промилль, 2014 оны 25.9 промилль үзүүлэлттэй болж 1990 онтой харьцуулахад 51.43 хувиар буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>1.3. Нялхасын эндэгдэл 2010 онд 22,8 промилль, 2011 онд 23,6 промилль, 2012 онд 23,7 промилль, 2013 онд 17,38 промилль ба 1000 амьд төрөлт тутамд 2013 онд 48 тохиолдол, 2014 онд 66 тохиолдол байна.</p> <p>2. Хүүхдийн шүдний кабинетийн эмч аймгийн төвийн 2, 3, 7, 8, 9, 10, 11-р цэцэрлэгүүдийн хүүхдэд амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж, хүүхдүүдийн дунд шүд цоорох өвчлөл бага, эхний шатанд байсан ба 9 бүлгийн 182 хүүхдэд шүд цооролтоос урьдчилан сэргийлэх лак болон мөнгөлөг наалт, 94 хүүхдэд цооролтоос урьдчилан сэргийлэх фторт лак түрхэж, 88 хүүхдэд цооролт зогсоох мөнгөлөг наалт, сафорайд түрхэх үйлчилгээ үзүүлсэн. /750.000 төг/. 2014 оны 10 сарын байдлаар 3846 шүд эмчилснээс 2245 шүдийг эрүүлжүүлсэн буюу 58,4%-тай байна. Мөн Цэнгэл сумын сум дундын эмнэлэг хуучин шүдний аппаратыг сэргээн засварласан. Үүний үр дүнд 2014 оны 6 дугаар сараас хойших хугацаанд нийт 585 хүнд шүд эмчлэх эрүүлжүүлэх тусламж үзүүлсэн. Сумын цэцэрлэгийн 200, сургуулийн 1400 хүүхдэд амны хөндийн үзлэг хийж шүдний өвчлөлийн байдалд судалгаа хийсэн.</p> <p>Амны хөндийн эрүүл мэндийн аяны хүрээнд 5 удаагийн олон нийтийн сургалтаар 1845 хүнд шүдний хуурай угаалгын аргыг зааж сургав.</p> <p>Өлгий сумын 2 дугаар бага сургуулийг шүдний өвчлөлгүй сургууль болгох зорилт тавьж, анги болгонд шүд угаах булан байрлуулан, үдийн цайны дараа хүүхэд бүрт шүдний хуурай угаалгын аргыг сургаж хэвшүүлсэн.</p> <p>Аймгийн өрхийн ЭМТөвүүд сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудтай хамтарч бүх сургуулийн 1-5 ангийн 3995</p>	<p>90%</p> <p>70%</p> <p>70%</p> <p>100%</p>	
--	--	--	--	--	---	--	--

					<p>сурагчдад шүд угаах, урьдчилан сэргийлэх аргыг зааж сургасан. Мөн Бугат сумын хүүхдийн эмч амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх талаар цэцэрлэгийн насны 76 хүүхдүүдэд, ЕБС-ийн 543 сурагчдад сургалт явуулж, амны хөндийг хэрхэн яаж угаах талаарх зурагтай 195 ширхэг зөвлөмж тараасан ба Алтанцөгц сумын 150 өрхөд “Амны хөндийн эрүүл ахуй шүд цоорох өвчнөөс сэргийлэх” сургалт зохион байгуулж үүнээс зорилтот бүлгийн 40 өрхөд шүдний сойз, саван, шүдний оо өгч эрүүл зөв дадлыг зааж сургаж. Нийт 320.000 төгрөг санхүүжилт зарцуулагдсан. Мөн “Дэлхийн Зөн” ОУБ эрүүл мэндийн төвүүдтэй хамтран 1350 хүүхдэд “Амны хөндийн эрүүл мэнд” үзүүлэх сургалт явуулж ба мөн энэ үеэр хүүхдийн сойз, шүдний оо, саке зэрэг 360.0 мянган төгрөгийн эд зүйлийг үнэгүй тарааж өгөв. Сургалтыг Өмнөд Солонгос улсаас ирсэн шүдний их эмч Ким Инатай хамтран явуулж туршлага солилцсон.</p> <p>3. Зэвсэгт хүчний 340-р ангийн бүх албан хаагч, хугацаат цэргийн 180 албан хаагч, хилийн цэргийн 0165-р ангийн хугацаат цэргийн 55 албан хаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ял эдэлж буй 22 ялтан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 17 албан хаагчдад ХДХВ /ДОХ/ БЗДХ-аас урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалт явуулж, тэмбүү, ХДХВ/ДОХ-ын шинжилгээнд хамруулсан. ХДХВ-ийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулсан. ХДХВ-ийн халдвар илрээгүй. Мөн аймгийн төвийн таксиний жолооч, хот хоорондын тээврийн 38 жолооч, МСҮТ-ийн дотуур байранд амьдарч буй 20 оюутан, нэгдсэн эмнэлгийн тасгуудад хэвтэн эмчлүүлж буй 85 үйлчлүүлэгч, 12 дугаар цэцэрлэгийн 14 багш, ажилчдад “ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх” талаар сургалт явуулж, гарын авлага, оролцогчдод 120 ширхэг бэлгэвч тараасан.</p> <p>3.2. “Нөхөн үржихүйн насны эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн эрүүл мэнд”- сэдэвт нээлтэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, 30 эмэгтэйгээс ХДХВ/БЗДХ-ын шинжилгээ авч, 20-30 насны ажилгүй 80 эмэгтэйчүүдэд ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх талаар мэдлэг олгох сургалт хийсэн. БЗДХ-ын кабинетэд 2014 онд 11-р сар хүртэл нян судлал болон ДОХ, Тэмбүүгийн шинжилгээнд нийт</p>	100%	
--	--	--	--	--	---	------	--

					<p>8584 хүн хамруулсан ба үүнээс жирэмсэн эмэгтэйчүүд давхардсан тоогоор 3439 хүн байна. Илэрсэн бүх өвчлөлийг хавьтагчтай нь хамт хяналтанд авч эмчилгээнд бүрэн хамруулсан.</p> <p>3.3. “Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян”-ы хүрээнд “НҮЭМ”, “БЗДХ, ХДХВ /ДОХ”-ын халдвараас урьдчилан сэргийлэх, “Охид, хөвгүүдийн хүмүүжил” сэдэвт сургалт зохион байгуулж МСҮТ, Ховд их сургуулийн харьяа Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль, Дорнод Казакстаны их сургуулийн харьяа Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль, 6-р ахлах Бүрэн дунд сургуулиудын дотуур байрны нийт 370 оюутан, сурагчдыг хамруулсан. Мөн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүдтэй хамт Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 5-8 –р ангийн 256 сурагчид, 4-р ахлах сургууль, “Дарын” ЕБС-ийн 15 аас дээш насны 8, 9, 10, 11, 12-р ангийн 324 сурагчдад “Бэлгийн бойжилт”, “Шилжилтийн нас”, “Охидын ариун цэвэр”, “Бэлгийн харьцаанд эрт орохоос сэргийлэх” НҮЭМ болон БЗДХ/ХДХВ/ДОХ-аас урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтыг зохион байгуулсан.</p> <p>- Дэлхий нийтээрээ ДОХ-той тэмцэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд өсвөр үеийн залуучуудад ХДХВ/ДОХ/БЗДХ-ийн талаар зөв мэдлэг олгох, эрүүл зан үйл төлөвшүүлэх, амьдрах ухаан олгох, урьдчилан сэргийлэх зорилгоор “Дэвжээ”- тэмцээнийг аймгийн ЗДТГ, ЭМГ, “Дэлхийн зөн”ОУБ, БӨ ОНХХ, ХГБХХ, байгууллагууд хамтран зохион байгуулж, МСҮТ, их, дээд сургуулиудын болон ЕБ-ын бүрэн дунд сургуулийн 10-11 дүгээр ангийн нийт 700 гаруй оюутан сурагчдыг хамруулж 10 баг болгон оролцуулж, эхний байранд шалгарсан сурагч хамт олныг шагнаан урамшуулсан. Мөн аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй “Думан”, “Серуен”, “Таван богд”, “Бастау”, “Цамбагарав” зочид буудалуудад бэлгэвч байгаа эсэх, зөв хэрэглэх заавруудыг өрөөнүүдэд наасан байдлуудад хяналт үнэлгээ хийж, зочид буудалын 18 ажилчдад “НҮЭМ, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын халдвараас урьдчилан сэргийлэх” сургалт хийж, илэрсэн алдаа зөрчилд арга зүйн зөвлөгөө өгсөн.</p> <p>БЗДХ-ын кабинетээр үйлчлүүлсэн 65 эрчүүдэд ХДХВ/ДОХ-ын талаар сургалт хийсний үр дүнд СДЗШ-ний кабинетэд хандаж бэлгэвч, зөвлөгөө авах эрчүүдийн тоо нэмэгдсэн. Мөн орон нутгийн “Наз” ТВ-</p>		
--	--	--	--	--	--	--	--

					<p>ээр Сайн дурын зөвлөгөө шинжилгээний кабинетийг сурталчилсан нэвтрүүлэг 1 удаа, ХДХВ/ДОХ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, бэлгэвчийг зөв хэрэглэх талаарх сургалт 1 удаа нэвтрүүлсэн.</p> <p>БЗДХ өвчин тус аймагт улс, аймгийн дунджаас бага байгаа.</p> <p>-Тархалтын түвшин 100000 хүн амд 11%,10000 хүн амд 1,1%-тай байна.</p> <p>3.4. Халдварт өвчин судлалын үндэсний төв болон сүрьеэгийн тасгийн эмчтэй хамтарч Дорнод Казакстан Улсын Их /ДКУИС/, Ховд их сургуулийн /ХИС/ салбар, МСҮТ-ийн 50 оюутан, ЕБС-ийн бэлтгэгдсэн үе тэнгийн 50 сурагч өсвөр үе, оюутан залуучуудын дунд “Шинэлэгээр сэтгэж, сүрьеэгийн тархалтыг зогсооё” сэдэвт сургалт, МСҮТ-ийн 54 эмэгтэй оюутны дунд нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн харьцаанд эрт орохоос сэргийлэх, бэлгийн замаар дамжих халдвар болон ХДХВ/ДОХ, халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх, хувийн ариун цэврийн талаар яриа хийж, МСҮТ-ийн 20 оюутаны дунд тус сэдвээр “АХА “ тэмцээнийг зохион явуулсан.</p> <p>3.5. Сүрьеэгийн диспансераар нийт үзлэг 3666 хүн, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 2887, амбулаториор анх үзүүлсэн 337, давтан үзүүлсэн 255, идэвхтэй хяналт 10, жилийн эхэнд хяналтанд байсан хүний тоо 13 байсан ба 23 болтлоо өсч, 13 хүн хяналтнаас хасагдаж 10 болж үлдсэн.</p> <p>- Сүрьеэгийн эмчилгээнд орсон хүмүүсийн ар гэрт нь голомтын судалгаа хийж үүнээс 0-16 насны хүүхдүүд болон төрөх насны эмэгтэйчүүд дотроос жирэмсэн эмэгтэйчүүдийн судалгааг нарийвчлан гаргаж жирэмсэн 2 эх болон төрөх насны 12 эмэгтэйд сүрьеэ өвчний талаар дэлгэрэнгүй сургалт явуулсан.</p> <p>- Түрхэц эерэг сүрьеэ өвчтэй үйлчлүүлэгчдийн ар гэрийн 0-16 насны хүүхдүүдэд туберкулений сорил тавьж, сорил эерэг илэрсэн 3 хүүхдийг урьдчилан сэргийлэх изониазийн эмчилгээнд оруулсан. Мөн “Сүрьеэтэй тэмцэх” ОУ-ын өдөрлөгөөр 24/III-нд радио, FM-ээр “Хүүхдийн сүрьеэ өвчин” сэдэвт нэвтрүүлэг, сурталчилгаа явуулсан.</p> <p>- “Дэлхийн Зөн” ОУ-ын санхүүжилтээр багшийн сургууль болон МСҮТөвийн нийт 80 орчим оюутан сурагчдыг хамруулан сүрьеэ өвчнийг хэн сайн мэдэх вэ? “АХА” уралдаант тэмцээн явуулж, түрүүлсэн 3</p>		
--	--	--	--	--	---	--	--

					<p>оюутанг шагнан урамшуулав.</p> <p>Сүрьеэгийн диспансераар нийт 41 өвчтөнг хяналтанд авсан ба үүний оношийн баталгаажилт-93,7%, эдгэрэлтийн түвшин-100%.</p> <p>Өвчлөлийн түвшин 100000 хүн амд 37,4%, 10000 хүн амд 3,7%-тай байна.</p> <p>3.6. Сүрьеэгээс шалтгаалсан нас баралт гараагүй.</p> <p>4. Алслагдсан багийн хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг Хөх хөтөлийн их эмчийн салбарт суурин хэлбэр болон нүүдлээр “Ах шохы” зуслангийн эмнэлгийн байраар үзүүлдэг эмнэлгийн 5 орны зөөлөн эдлэл, өвчтний болон ажилтны сандал ширээг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шийдвэрлэж 1.410.000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.</p> <p>Цэнгэл суманд нүүдлийн их эмчийн салбарыг аймаг болон сум хөгжүүлэх сангийн дэмжлэгээр 1, 2, 3, 5 дугаар багийн иргэдэд 2014 оны 3 дугаар сарын 20-оос 5 дугаар сарын 1 нд ажиллуулж, 412 дуудлага, 754 эмчийн үзлэг хийж 26 жирэмснийг хяналтын үзлэгт хамруулсан байна. Мөн цоохор харганы эмнэлгээр 6 дугаар сарын 23-наас 8 дугаар сарын 29-нд 1, 2, 3, 5 дугаар багийн 510 дуудлага, 130 хүн амд эмчийн үзлэг, 15 хүнийг хэвтүүлэн эмчилсэн.</p> <p>- Зуны улиралд сумаараа нүүдэллэж эмнэлгийн тусламж үзүүлдэг Алтанцөгц сумын 101, Баяннуур сум 116, Ногооннуур 159 хүнийг тус тус хэвтүүлэн эмчилж, нийт 1735 хүнд нүүдлийн эмнэлгээр тусламж үзүүлсэн бол Сагсай сумын Даян багт багийн бага эмчийн салбараар дамжуулан 1, 2, 3, 6 дугаар багийн 3000 орчим иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг ямар нэг байдлаар үзүүлээд байна.</p>	90%	
--	--	--	--	--	--	-----	--

13	<p>4.5.2. Аймаг, дүүргийн болон улсын клиникийн нэгдсэн эмнэлэг, мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны чадамжийг хөгжүүлнэ.</p> <p>1. Хорт хавдрыг эрт оношлох, эмчлэх боломжоор аймаг, дүүргийн эмнэлгийг хангах</p> <ul style="list-style-type: none"> - Хорт хавдрын эрт илрүүлэлт: <ul style="list-style-type: none"> - I үе - II үе - Хорт хавдар нь оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний эзлэх хувь: <ul style="list-style-type: none"> - умайн хүзүүний хорт хавдар - хөхний хорт хавдар <p>4. Алсын зайны оношилгоо, эмчилгээний аргуудыг эмнэлэгт нэвтрүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Алсын зайн оношилгоо, эмчилгээний аргыг нэвтрүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо 	НХХ, ЭМГ	<p>ЭМСайдын 183 тоот тушаалаар батлагдсан “Элэгний хорт хавдрын стратеги”-ийг аймагт хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу түүний хэрэгжилтэнд хяналт тавьж, мэргэжил болон удирдлагаар хангах хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын А/666 тоот захирамжаар батлаж, удирдах мэргэжил арга зүйгээр хангах ажлын хэсгийн хурлыг зохион байгуулав. Мөн хорт хавдрын эсрэг аянг 2015 онд дахин зохион байгуулах үүднээс ХСҮТөвтэй хамтран ажиллах талаар хүсэлтээ уламжилав. 2014 онд Шинэчлэлийн Засгийн Газрын хөрөнгө оруулалтаар 2 тэрбум 228 сая 143.000 төгрөгийн 73 төрлийн аппаратууд нийлүүлэгдэн оношлогоо, эмчилгээний нөхцөл сайжирсан.</p> <p>Хорт хавдрын эрт илрүүлэлт 121. Үүнээс: I үе шат – 1 хүн II үе шат – 15 хүн оношлогдсон.</p> <p>- Хорт хавдар нь оношлогдсоноос хойш 5-аас дээш жил амьдарсан хүний тоо нийт 12. Үүнээс: Умайн хүзүүний хорт хавдар - 4 хөхний хорт хавдар – 5 байна.</p> <p>4. 2014 оны байдлаар Нэгдсэн Эмнэлгийн амбулаторын компьютер томограф оношилгооны кабинетээс улсын төв клиникүүдэд нийт 72 удаа зайн оношлогооны үйлчилгээ авсан. Мөн Ногооннуур, Цэнгэл сум дундын эмнэлэг, Буянт, Толбо, Сагсай, Улаанхус сум, Цагааннуур тосгоны ЭМТөвүүд интернетийн сүлжээнд холбогдож телемедицин, зайн оношлогооны дэд бүтэц шийдэгдсэн ба аймгийн НЭ-ийн сургалтын танхимын телемедицины сүлжээгээр 2014 оны байдлаар ЭМЯам, ЭМХТөв, Улсын төв клиникүүдэд нийт 132 удаа хурал, семинар, сургалтанд амжилттай холбогдлоо.</p> <p>Эрүүл мэндийн статистик бүртгэл, боловсруулалтын H-info V.3.0 программ гарснаар төрөлт, нас баралт, өвчлөлийн мэдээг цахим хэлбэрээр бүртгэж, боловсруулалт хийн ажиллаж байна.</p>	100%	100%
14	<p>4.5.3. Эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай боловсон хүчнээр хангана.</p> <p>1. Эрүүл мэндийн байгууллагыг үйлчлүүлэгчээ дээдэлсэн үйл ажиллагааны зарчимтай болгох</p>	НХХ, ЭМГ	<p>1. Аймгийн эрүүл мэндийн байгууллагууд үйлчлүүлэгчээ дээдлэн дараах ажлуудыг зохион байгуулсан. Тус аймагт нийт 23 төрлийн эмнэлэг үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд дор бүрнээ:</p> <ul style="list-style-type: none"> - Үйлчлүүлэгчээ угтах хөтөч үйлчилгээ 		

		<p>- Эрүүл мэндийн байгууллага, эмч, мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний зарчмыг мөрдлөг болгон ажилласан байна</p> <p>2. Хүний нөөц, мэргэжлийн ур чадварын сургалтыг олон улсын жишигт хүргэх</p> <p>- Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй болсон байна</p>			<p>- Сэтгэлд нийцсэн 8 үйлчилгээг байгуулагдаа нэвтрүүлсэн</p> <p>- Иргэдийн санал, гомдлыг барагдуулах үүднээс ЭМСайдын 2013 оны 312 дугаар тушаалын дагуу байгууллагуудаас сар бүр мэдээ авч тухайн байгууллагад ямар санал, гомдол байгаад дүн шинжилгээ хийж түүний мөрөөр ажил зохион байгуулж, ажлын чиглэлд зөвлөмж өгч ажилласан. Үүний үр дүнд ЭМСайдын 2012 оны Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай 427 дугаар тушаалын дагуу эмнэлгийн байгууллагуудын ор болон үйлчилгээний хүлээгдлийг бүртгэн хүлээгдэл багасгах ажлуудыг зохион байгуулснаар тухай бүр хүлээгдэл зохих түвшинд буурч байгаа.</p> <p>2. Шинэчлэлийн Засгийн газрын бодлого төлөвлөлтийн дагуу Ерөнхий сайдын багцаас аймгийн нэгдсэн эмнэлэгт “Оношилгооны төв” байгуулагдаж, оношлогооны аппарат тоног төхөөрөмжийг ажиллуулах эмнэлгийн мэргэжилтнүүдийг төрийн зардлаар төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд компьютер томографийн эмч-1, техникч-1, тархины судасны депплерографийн эмч-1, нүдний эмч-1, нүдний сувилагч-1, лабораторын эмч-1, иммунологийн лаборант-1, бөөрний эмч, сувилагч нийт 9 мэргэжилтэн бэлтгэгдэн орон нутагт ажиллаж байна. Эмнэлгийн дээд мэргэжилтний давтан сургалтанд 2 их эмч, төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтанд 4 их эмч, эмнэлгийн тусгай дунд мэргэжилтний 1-3 сарын мэргэжил олгох, эзэмшүүлэх, дээшлүүлэх сургалтанд төрийн сангийн зардлаар 17, байгууллагын зардлаар 4, хувийн зардлаар 3 сувилагчид эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан. Мөн гадаадад болон БНСУлсад яаралтай тусламжийн мэргэжил дээшлүүлэх болон эх барих эмэгтэйчүүдийн эмч гэсэн 2 чиглэлээр 1 сарын сургалтанд 2 их эмч, ОХУ-д хүүхдийн 1 эмч, БНХАУ-ын Алтай аймагт Уламжлалт анагаах ухааны чиглэлээр нэгдсэн эмнэлгийн нэг эмч, 2 сувилагч нар тус тус улсын зардлаар суралцаж мэргэжилээ дээдшлүүлсэн.</p> <p>Орон нутагт хэрэгжиж буй Норвегийн тусламжийн байгууллагын Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх-2 төслийн санхүүжилтээр зохион байгуулагдсан 16 удаагийн сургалтанд 444 эмнэлгийн</p>	<p>90%</p> <p>100%</p>	
--	--	---	--	--	---	------------------------	--

					<p>мэргэжилтэн, эмч мэргэжилтний зайны сургалтанд давхардсан тоогоор 288 эмч, мэргэжилтэн, мөн орон нутагт зохион байгуулагдсан 13 удаагийн богино хугацааны багц цагийн сургалтанд давхардсан тоогоор 1252 эмч, эмнэлгийн тусгай дунд мэргэжилтнүүд тус тус хамрагдсан. 2014 оны богино хугацааны албан ба албан бус сургалтанд давхардсан тоогоор нийт 1985 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдан, биелүүлвэл зохих багц цагийг биелүүлэн, мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн.</p>		
15		<p>4.5.4. Хүн амын өвчлөл, цаг бусын нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг ахиулна. Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлнэ.</p> <p>1. Хүн амд амьдралын зөв зохистой хэвшил, бие бялдраа чийрэгжүүлэх орчин бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих бодлогын баримт бичигтэй болсон байна - Илүүдэл жинтэй ба таргалалттай хүн амын эзлэх хувь - Хөдөлгөөний хомсдолтой хүн амын эзлэх хувь 			<p>НХХ, ЭМГ</p> <p>1.1. Албан байгууллага, ЕБСургууль, цэцэрлэгт ажиллах ажлын удирдамж боловсруулж, тухайн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нартай хамтарч ажиллах ажлын хэсэг байгуулж, ажилчдын бие бялдрын түвшин тогтоох сорил авах, ажлын байрны дасгал заах, “Эрүүл мэнд-идэвхтэй хөдөлгөөн” сэдэвт сургалт явуулах, олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, өдөрлөг зохион байгуулах, ажилчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, чийрэгжүүлэлтийн танхим байгуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулан явуулсан. Эдгээрээс дурдахад:</p> <ul style="list-style-type: none"> - “Мөнгөн өвөл” өдөрлөгөөр нийт 14 байгууллагын 445 ажилчид хамрагдсан - “Идэвхтэй хөдөлгөөн-Эрүүл мэнд сэдэвт бүх нийтийн кросс гүйлтэнд 160 хүн хамрагдсан - Аймгийн төвийн их, дээд сургуулийн 254 оюутан залуучуудын өдөрлөг зохион байгуулагдсан - “Ахмад настны эрүүл мэндийг дэмжих” сарын аяны хүрээнд “Идэвхтэй хөдөлгөөн-эрүүл насжилт” сэдэвт өдөрлөгийг Ахмадын хороотой хамтарч зохион байгуулж, 120 ахмад настанд хийн дасгал хийлгэсэн. -ЕБСургуулийн сурагчдын хичээлийн завсарлагаанаар хийх дасгалыг 510 сурагчдад зааж эзэмшүүлсэн. -“Эрүүл нийгэм-эрүүл амьдрал”-ын төлөө хамтдаа сэдэвт өдөрлөгт 1000 хүүхэд уран хөдөлгөөнт гимнастикийг аймгийн төв талбайд хийж үзүүлсэн. - ЕБСургуулийн бага ангийн 140 сурагчдын дунд “Уран хөдөлгөөнт гимнастик”-ийн тэмцээн зохион явуулсан. - Цэцэрлэгийн хүүхдийн дунд хүүхдийн бие бялдрыг чийрэгжүүлэх, эрүүл зан үйлийг эзэмшүүлэх, хүүхдэд таатай орчин бүрдүүлэх, дэмжих, туршлага солилцох зорилгоор “Эрүүл чийрэг хүүхэд” сэдэвт үзүүлэх сургалтуудыг тус тус зохион байгуулсан. 	100%	

					<p>Мөн чийрэгжүүлэх танхимд тогтмол цагийн хуваарийн дагуу эрүүл болон эмчийн магадалгаатай өвчлөмтгий хүүхдүүдэд аэробик гимнастик ба эмчилгээний дасгалд 78 хүүхдийг хамруулан хичээллүүлсэн ба илүүдэл жинтэй хөдөлгөөний хомсдолтой 10 эмэгтэйчүүдэд чийрэгжүүлэх аэробикээр хичээллүүлж байна.</p> <p>1.2. 2014 онд “Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр батлагдаж хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Илүүдэл жинтэй ба таргалалттай хүн ам 29,7%-тай байна.</p> <p>1.3. Хөдөлгөөний хомсдолтой хүн ам 45% эзлэж байна.</p>	50%	
4.6. Соёл, урлагийн хөгжлийн бодлого							
16		<p>4.6.1. Үндэсний соёлыг эрчимтэй хөгжүүлэх эдийн засаг, зохион байгуулалтын тааламжтай орчинг бүрдүүлнэ.</p> <p>1. Соёлын удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт зах зээлийн эдийн засгийн горимд шилжих үйл явцыг түргэтгэж, салбарын бүх шатанд мэргэжлийн ба удирдлагын ур чадварыг дээшлүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Соёл, урлагийн санхүүжилтэд улсын төсвийн бус эх үүсвэр (хувь) - Нийт ажилтанд мэргэжилтэй ажилтны эзлэх хувь - Жилд мэргэшил дээшлүүлсэн ажилтны хувь <p>2. Үндэсний болон олон улсын хэмжээнд томоохон ач холбогдолтой бүтээл, туурвил, арга хэмжээг хөгжлийн сангуудаас тодорхой хувиар санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Хөгжлийн сангуудаас соёл, урлагийн бүтээлд зарцуулсан хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөгөөр) 			<p>1.1. Соёл, урлагийн санхүүжилтэд улсын төсвийн бус эх үүсвэр -23%</p> <p>1.2. Нийт ажилтанд мэргэжилтэй ажилтны эзлэх хувь- 47</p> <p>1.3. Жилд мэргэшил дээшлүүлсэн ажилтан 3%-тай байна.</p> <p>2. Хөгжлийн сангуудаас соёл, урлагийн бүтээлд зарцуулсан хөрөнгийн хэмжээ 0.985 тэрбум төгрөг</p>	70	90%

17	<p>4.6.2. Хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангах талаар дорвитой ахиц гаргана.</p> <p>1. Монгол Улсын үндэстэн, ястан, үндэсний цөөнхийн болон хүн амын янз бүрийн давхрагуудын оюуны хэрэгцээг үе шаттай судлан тодорхойлж, тэдгээрт тохирсон соёл, урлагийн үйлчилгээний төрөл, үр ашигтай арга хэлбэрийг сонгож хэрэглэх</p> <ul style="list-style-type: none"> - Эрх зүйн орчин, санхүүжилтийн өсөлтийн хувь, бий болсон үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ <p>3. Монголчуудын уламжлалт соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, сэргээх, үндэсний хийгээд дэлхий дахины танин мэдэхүй, боловсролын нийтлэг хүртээл болгон дэлгэрүүлэн хөгжүүлэх үйл ажиллагааг төрийн бодлогоор дэмжих</p> <ul style="list-style-type: none"> - Зарцуулсан хөрөнгийн хэмжээ (тэрбум төгрөг) - Улсын нэгдсэн бүртгэлд авсан түүх соёлын хөдлөх, үл хөдлөх дурсгалын тоо - Биет бус соёлын өвийг өвлөн тээгчийн тоо <p>4. Үндэсний уламжлалт болон сонгодог урлаг, хүүхдэд зориулсан урлагийн төрлийг төрөөс дэмжих үндэсний хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Төрөөс үзүүлсэн санхүүгийн дэмжлэг (тэрбум төгрөг) <p>5. Соёл, урлагийн байгууллагуудын материаллаг бааз, барилга байгууламжийн зориулалт, эрүүл ахуй, гоо зүй, техникийн болон үйлчилгээний чанарт тавигдах орчин үеийн хэрэгцээ шаардлагыг тусгасан стандартыг боловсруулж мөрдөх</p> <ul style="list-style-type: none"> - Шаардлага хангасан орчин бүхий соёл, урлагийн байгууллагын эзлэх хувь 			<p>НХХ, ССА ЖГ</p>	<p>1. Аймгийн төвд Нийтийн номын сангийн байр шинээр ашиглалтанд орсон. Тус номын санд:</p> <ul style="list-style-type: none"> - Цахим номын сан бий болсон - Ном уншлагын заал 1-ээр нэмэгдсэн. <p>Мөн аймгийн төвд Хүүхэд залуучуудын парк, бүх сумдын Соёл үйлчилгээний төвүүдэд орчин үеийн кино гаргалтын шинээр аппараттай болсон ба Улаанхус сумын Согог багт Соёлын төвийн байр тус тус шинээр ашиглалтанд орсон.</p> <p>3.1. Хөрөнгө зарцуулалт гаргаагүй.</p> <p>3.2. Улсын нэгдсэн бүртгэлд авсан түүх соёлын хөдлөх, үл хөдлөх дурсгалын тоо—3520 ш</p> <p>3.3. Биет бус соёлын өвийг өвлөн тээгчийн тоо-345 хүн байгаа ба үүний 2 хүн ЮНЕСКО-д өв тээгчээр бүртгэгдсэн.</p> <p>4. Ёс заншил, хэл, ахуй соёлоороо ялгаатай баруун Монголын хүүхдүүд гурван өдрийн турш Ховд аймагт зохион байгуулагдсан "Баруун Монголын Хүүхдүүд" нэгдсэн хоёрдугаар чуулганд амжилттай оролцсон ба чуулганы үр дүнд нь хүүхдийн оролцоог бүх талаар дэмжин хүүхдүүдтэй хамтран ажиллах, хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх нийгмийн үйлчилгээг бодитойгоор бий болгох уриалгыг өрх гэр бүл, аж ахуйн нэгж байгууллага, бүх шатны бодлого боловсруулан шийдвэр гаргагч, олон нийтэд хандан гаргахаар болов.</p> <p>5. Шаардлага хангасан орчин бүхий соёл, урлагийн байгууллагын эзлэх хувь - 62.5</p>	<p>100%</p> <p>70%</p> <p>30%</p> <p>70%</p>
4.8. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн бодлого						
18	<p>4.8.1. Гэр бүл, нийгэм, хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлнэ.</p> <p>1. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийн хэрэгцээ, сонголтод түшиглэсэн халамжийн олон талт үйлчилгээг бий болгож, үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын</p>			<p>НХХ, НХҮХ</p>	<p>1. “Жангарай” үдийн эмнэлэг, зорилтод бүлгийн иргэдэд амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар олгох, хөдөлмөрийн дадал олгох сургалтыг аймгийн “Эмэгтэйчүүдийн холбоо” зэрэг ТББ-аар гэрээгээр гүйцэтгүүлэхээр дээд шатны байгууллага үйлчилгээ явуулах эрх олгосон. Үүний дараа хамтран ажиллах гэрээ байгуулан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээг зорилтод</p>	

		<p>оролцоотойгоор хүргэх тогтолцоог бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн халамжийн тогтолцооны шинэчлэл хийгдсэн, цаашид боловсронгуй болсон байна. Нийгмийн халамж хүртэгсдийн мэдээллийн санг бүрдүүлсэн байна. <p>2. Хөдөөгийн хүн амд зориулсан нийгмийн явуулын үйлчилгээг хөгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Явуулын үйлчилгээ явуулах нэгжийн тоо, хамрагдсан иргэдийн тоо 			<p>бүлгийн иргэдэд хүргүүлэн ажилласан. Үүнд: 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ХБХЭЭХ-ны дэргэдэх сэргээн засах төв нь нийт 48 хүүхдэд нөхөн сэргээх, сэргээн засварлах үйлчилгээ үзүүлсэн. Мөн “Жангарай” үдийн эмнэлэг 15 ахмад настан, 3 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд уламжлалт аргаар сэргээн засах үйлчилгээ үзүүлж, үүнд 1.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Харин аймгийн эмэгтэйчүүдийн холбоо нь зорилтод бүлгийн иргэдэд амьдралын итгэл үнэмшил олгох, бие даан амьдрах чадвар олгох, хөдөлмөрийн дадал олгох гэсэн сургалтуудыг зохион байгуулж, үүнд 3,0 сая төгрөг зарцуулсан.</p> <p>Улсын хэмжээнд 2013 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан Орлогыг орлуулан тооцох аргачлалаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны үр дүнгээр мэдээллийн сантай болсон. Мэдээллийн санд 18772 өрхийн мэдээлэл орсон буюу 99,89% хамрагдсан байна. Уг судалгааны үр дүнгээр хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд нийт 398 өрх хамрагдахаар эрх авч эдгээр өрхийн насанд хүрсэн 1258 хүнд болон 1308 хүүхдэд 193.975.000 төгрөгийн үйлчилгээг цаг хугацаанд нь чирэгдэлгүйгээр үйлчилсэн.</p> <p>2. Явуулын үйлчилгээ үзүүлэх ажлын хэсэг нь хөдөө сумдад ажиллаж, сум хариуцсан нийгмийн халамжийн мэргэжилтнүүдийн ажилд хяналт, шалгалт хийж нийт 8 сумын 320 иргэнийг нийгмийн халамжийн зүгээс зорилтот бүлгийн иргэдэд үзүүлж буй үйлчилгээний талаар мэдээ мэдээллээр хангаж, Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжийг сурталчилж, иргэдийн сонирхсон асуултанд тухай бүр хариу өгч ажилласан.</p>	<p>90%</p> <p>70%</p>	
--	--	--	--	--	--	-----------------------	--

19		<p>4.8.2. Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай болгож, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ</p> <p>1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгааг өргөжүүлж, ажил олгогч, ажил хайгчид, мэргэжлийн сургалтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> - Чадамжид суурилсан ур чадварыг хөгжүүлэх сургалтын тогтолцоог нэвтрүүлсэн байна <p>4. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний хүрээнд төрөлжсөн бизнес инкубаторыг байгуулан ажиллуулж, жижиг зээл, ажлын байран дахь болон шавь сургалтыг өргөтгөх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Ажиллах хүчний оролцооны түвшин 			НХХ, ХөдХ	<p>1. Аймгийн ҮЭХ, ажил олгогч эздийн нэгдсэн холбоо /АОЭНХ/–той хамтарч аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын судалгааг гаргаж, салбар салбараар нь цалин хөлсний бүтцийн судалгааг гаргаж, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хамтын гэрээ, хэлэлцээрээр ажил олгогч, ажилтны төлөөлөлтэй хамтран тогтоож мөрдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, гарын авлага хангаж ажилласан. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний /ХХДХ/ тухай хуулийн биелэлтийг хангуулж, мөрдүүлэхээр аймгийн Засаг даргын 1-1/2540 дугаар албан даалгаврыг бүх сумуудад болон аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлсэн. 2013 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн ХХДХ-г 192.000 төгрөгөөр /Салбар бүрээр нь авч үзвэл: Барилгын салбар-358848 төгрөг, Эрүүл мэндийн салбар-182520 төгрөг, Эрдэс баялаг, эрчим хүчний салбар-224640 төгрөг, Авто тээврийн салбарт-201600 төгрөгөөр/ тогтоосон. Үүнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын өгсөн үүрэг даалгавар буюу ХХДХ-ний хэрэгжилтэд аж ахуйн нэгж, байгууллагуудад мөрдлөг болгон хэрэгжүүлж буй эсхэд аймгийн ҮЭХ болон холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хамтарч байнга хяналт тавьж ажиллаж байна. Мөн МУЗГ 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт цалин, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан нэмэгдүүлэх зорилт тависаны дагуу 2014 оны 2 дугаар сарыг аймгийн хэмжээнд “Хөдөлмөрийн бүтээмжийн сарын аяны”-ыг бүх ААН, байгууллагуудад өрнүүлэх ажлын хэсэг байгуулан ажиллуулсан ба ажлын явцын талаарх мэдээллийг аймгийн хэвлэл мэдээлэл, радиогоор 2014 оны 02–р сард тайлагнасан.</p> <p>2014 онд нийт 2081 иргэнд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үзүүлж, зөвлөгөө өгсөн. Үүнд: Бүлгээр зөвлөгөө өгөх үйлчилгээнд 1995 иргэн хамрагдсаны 1002 эмэгтэй, 86 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгөх үйлчилгээнд 46 нь эмэгтэйчүүд байсан ба уг ганцаарчилсан зөвлөгөө авсан нийт иргэдийн 78% буюу 67 иргэн мэргэжлийн сургалтад хамрагдаж, ямар нэг байдлаар ажлын байртай болсон.</p> <p>Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үүднээс</p>	90%	
----	--	--	--	--	-----------	--	-----	--

					<p>“Аймгийн залуучуудын хөдөлмөрийн чуулга уулзалт”-ыг зохион байгуулж, санал солилцон “зөвлөмж” гаргасан ба 1375 иргэдэд ажлын байранд зуучлах үйлчилгээг үзүүлсэн. 2014 оны жилийн эцсийн байдлаар нийт 1500 ажилгүй иргэдийг бүртгэж, аймгийн хэмжээнд 200 аж ахуйн нэгж байгууллагуудыг LMIS програмд оруулсан ба эдгээр байгууллагуудын ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээллийг мөн адил хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд оруулсан болно. Тус хэлтэст бүтэн жилийн байдлаар ажил олгогчдоос 1516 ажлын байрны захиалга авч, ажлын байрны захиалгыг ард иргэдэд радио, телевиз, интернэтээр байнга мэдээлж, ажил хайж байгаа иргэдийн хүсэл сонирхол, мэргэжил, ур чадварт нь тохирсон ажил олоход туслалцаа үзүүлж, нийт 1375 иргэнд ажилд зуучлах үйлчилгээ үзүүлэв.</p> <p>4. “Аймгийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн зөвлөгөөн” болон “Хоршоо ахуй үйлчилгээ эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг 3 болон 5 дугаар саруудад аймгийн ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс, АОЭНХ, ҮЭХ болон “Дэлхийн Зөн” ОУБ-тай хамтран зохион байгуулсан. Мөн аймгийн ЖДҮ эрхлэгчид 2014 оны 3 дугаар сард сум тус бүрээс ЖДҮ эрхлэгчид төлөөлөл болох 2 хүн буюу нийт 26 хүн Ховд аймгийн жижиг дунд үйлдвэрлэлтэй танилцаж, туршлага судалсан. Зөвлөгөөний үеэр төр засгаас ЖДҮ-ийг хөгжүүлэх талаар баримталж буй бодлого, холбогдох хууль тогтоомж, аймгийн ЖДҮ-ийн өнөөгийн байдал, тулгамдаж буй бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар танилцуулж, зөвлөгөөнд оролцогчдоос гарсан санал бодлуудыг үндэслэн зөвлөмж, төлөвлөгөө боловсруулан бүх сумдад хүргүүлэн ажил хэрэг болгон ажиллаж байна.</p>	70%	
--	--	--	--	--	---	-----	--

20		<p>4.8.3. Хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.</p> <p>1. Эмэгтэйчүүд, ахмад настан, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг хүн амын болон нийгмийн бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлж, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Эмэгтэйчүүд, ахмад настан, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг хүн амын болон нийгмийн бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд батлагдаж хэрэгжсэн байна <p>2. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээлэл, зохион байгуулалтыг сайжруулж, төр, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэлийн тогтолцоо бүрдсэн байна - Албан бус хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан нийгмийн даатгалын тогтолцоо бүрдүүлсэн хууль батлагдан гарсан байна. 			НХХ, ХөдХ	<p>1. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн 2014 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай 5 сумыг сонгосон. Үүнд: Алтай, Буянт, Улаанхус, Цэнгэл, Булган сумууд сонгогдсон бөгөөд багийн нийтийн хурлын тогтоол, сумын амьжиргааг дэмжих зөвлөл болон сумын Засаг даргаар баталгаажуулсан 25 малчны материалыг сумдаас хүлээн авч төслийн сонгон шалгаруулах ажлын хэсгийн шийдвэрээр 25 малчин өрхийг хөтөлбөрт хамруулсан.</p> <p>Уг хөтөлбөрийн хүрээнд 25 малчин тус бүрт Хөдөлмөрийн хэлтсээс 5.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамруулж 3 жилийн хугацаатай 50 хувь буюу 2.5 сая төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэй гэрээ байгуулав. Үүний үр дүнд: 25 малчид нийт 1372 толгой мал /625 нь хонь, 729 ямаа, 1 адуу, 17 үхэр/ худалдан авсан. Малчин тус бүрт өгсөн 5 сая төгрөгийн 4.0 сая төгрөгт нь мал худалдан аваад үлдсэн 1.0 сая төгрөгийг хашаа хороо засварлах, худаг гаргах, хадлан тэжээл бэлтгэх, сургалтанд хамрагдах зэрэг үйл ажиллагаанд зарцуулсан байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан /ХЭДС/-гаас малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт нийт 125.0 сая төгрөг зарцуулагдсан ба үүний үр дүнд малчдын малын тоо толгой нэмэгдэж, өрхийн орлого нь мэдэгдэхүйц нэмэгдсэн.</p> <p>2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 32 иргэн байнгын ажлын байраар, 15 иргэн түр ажлын байртай болсон. Мөн 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүн авч ажиллуулах талаар байнга шаардлага тавьж ажилласан. Үүний үр дүнд 40 хүн ажил хөдөлмөр эрхэлж ажлын байраа хадгалан ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай дансанд 5 сая 626 мянга 400 төгрөгийг төвлөрүүлсэн.</p>	70%	
21		<p>4.8.4. Нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно</p> <p>1. Хуулийн этгээдэд ажиллаж байгаа хүн бүр</p>			НХХ, НДХ	<p>Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх чиглэлээр одоогийн мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд ажлууд тогтмол хийгдэж байна.</p>		

		<p>нийгмийн даатгалд заавал хамрагдах зарчимд шилжих</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн даатгалын шинэчлэлийн хүрээнд заавал даатгалын хамрах хүрээг өргөтгөх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон байна 				<p>2014 онд шинээр 25 ажил олгогч Нийгмийн даатгалд шинээр бүртгүүлэн хамрагдсанаар 100 гаруй даатгуулагч нэмэгдэж тодорхой хувиар хамрах хүрээ өргөжсөн.</p>	70%		
<p align="center">Хөгжлийн 2 дугаар тэргүүлэх чиглэл: Тав. Эдийн засгийн өсөлт, хөгжлийн бодлогын хүрээнд: 5.1. Макро эдийн засгийн бодлого 5.1.1. Улсын төсвийн бодлого</p>									
22		<p>5.1.1.1. Төсвийн төлөвлөлтийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд нийцүүлэн боловсронгуй болгоно</p> <p>3. Төсвийг төсвийн байгууллагуудын бодит хэрэгцээнд нь нийцүүлэн төлөвлөж, санхүүжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Төсөвт байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, нийлүүлэх бүтээгдэхүүний тоо хэмжээ 			СТСХ	<p>Төсвийн төлөвлөлтийг улам боловсронгуй болгох ажил тасралтгүй явагдаж байна. 2013 оноос Төсвийн тухай хууль бүрэн хэмжээгээр хэрэгжиж эхлэв. Үүнтэй холбогдуулан орон нутгийн төсвийн эрх хэмжээг нэмэгдүүлж, боловсрол, соёл, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир зэрэг 7 төрлийн тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийг орон нутаг өөрөө баталдаг болсон. Орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зориулж Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгээр тодорхой хөрөнгийг аймаг, сумын эрх мэдэлд өгсөн</p> <p>3. Төсвийг хөтөлбөрөөр төлөвлөдөг системд шилжүүлэн хөтөлбөр, зарлагын эдийн засгийн ангилал, зориулалтын ангиллыг шинэчлэн баталж 2015 оны 1 дүгээр сараас мөрдөж эхэлсэн. Цаашид хөтөлбөрийн биелэлтийг төсөвтэй уялдуулан тайлагнах зарчимд шилжиж төсвийн төлөвлөлтийг бодит хэрэгцээ, хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд норм, нормативт шилжүүлэх ажлуудыг хийж эхэлсэн.</p>	90%		
23		<p>5.1.1.2. Төсвийн хөрөнгө оруулалтыг Мянганы хөгжлийн зорилтуудтай оновчтой уялдуулан нэмэгдүүлж, урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд суурилан хэрэгжүүлнэ</p> <p>1. Төсвийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн хөгжлийн индекст тулгуурлан зорилтот хөтөлбөрүүд, эдийн засаг, нийгмийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө, төслүүдэд үндэслэн хуваарилах</p> <ul style="list-style-type: none"> - Төсвийн хөрөнгө оруулалтын нийт дүнд хөтөлбөр, мастер төлөвлөгөө, төслүүдэд тулгуурласан төслийн эзлэх хувь, хэмжээний өсөлт <p>2. Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Улсын төсвийн хөрөнгөөр дэд бүтцийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтын жил бүрийн тоо хэмжээ 			СТСХ	<p>1. Аймаг орон нутагт жил бүр хуваарилагдаж байгаа ОНХСангийн хөрөнгө оруулалтыг аймаг, сумдын хөгжлийн индексийг харгалзан хуваарилж, аймаг, сумдын хөгжлийн стратегийн төлөвлөгөө, бодлоготой уялдуулан тухайн шатны ИТХурлаар хэлэлцүүлэн батлуулан ажиллаж байна. 2014 онд ОНХСангаас 10,4 тэрбум төгрөг, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 11,9 тэрбум, сайдын багцаас их засварт зориулж 6,3 тэрбум нийт 28,6 тэрбум төгрөгийн хөрөнгө хуваарилагдаж хэрэгжсэн.</p> <p>2. Орон сууц барихад хувийн хөрөнгө оруулалтаас 14,1 тэрбум, Барилгын материалын үйлдвэрт хувийн хөрөнгөөр 4,5 тэрбум төрөг зарцуулсан. Үүнээс үзэхэд барилгын материал үйлдвэрийг дэмжих хөтөлбөр болон 1000 айлын орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 18,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулаад байна.</p>	100	70%	

		<p>3. Боловсрол, эрүүл мэндийн салбарт, ялангуяа бүс нутаг, хөдөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг Мянганы хөгжлийн зорилтуудтай уялдуулан тогтмол нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар боловсрол эрүүл мэнд, бүс нутаг, хөдөөд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээний өсөлт <p>4. Мэдээлэл, холбооны орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх, мэргэжлийн боловсрол олгох тогтолцоог сайжруулахын тулд төсвийн хөрөнгө оруулалтаар дэмжлэг үзүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Мэдээлэл, холбоо, мэргэжлийн боловсрол олгох арга хэмжээнд зарцуулсан төсвийн хөрөнгө оруулалтын жил бүрийн тоо хэмжээ, өсөлт 			<p>3. Аймгийн хэмжээгээр дэд бүтцийн салбарт 2011 онд 8849,5 сая, 2012 онд 22005,0 сая төгрөг, 2013 онд 24432,0 сая төгрөг 2014 онд харилцаа холбоо, улс орон нутгийн чиглэлийн авто зам, баруун бүсийн босоо тэнхлэгийн зам зэрэгт улсаас нийт 60825,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.</p> <p>4. Мэдээлэл, харилцаа, холбооны үндсэн суурь сүлжээ болох өндөр хурдны шилэн кабельд 12 сум, 1 тосгон холбогдсон. Хөрөнгө оруулалтын тоо хэмжээ эцсийн байдлаар гараагүй байна.</p>	70%	
24		<p>5.1.1.3. Хүн амын орлого багатай ядуу болон дундаж орлоготой хэсэгт түлхүү хандсан төсвийн зарлагын бодлого хэрэгжүүлнэ.</p> <p>1. Ажлын байр шинээр бий болгох, бүх нийтийн боловсролын түвшинг дээшлүүлэх, эх, хүүхдийн эндэгдэл, халдварт өвчний тархалтыг бууруулахад зориулах төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Эх, хүүхдийн эндэгдэл буурсан тоо, халдварт өвчний тархалт буурсан тоо 		НХХ ЭМГ	<p>- 2013 онд 4 эх эндсэн /Дэлүүн, Ногооннуур, Улаанхус, Өлгий сум/ ба 100 000 амьд төрөлтөд 144,8 байна.</p> <p>2014 онд 2014 онд 1 тохиолдол гарч буурсан үзүүлэлттэй байна.</p> <ul style="list-style-type: none"> - 0-1 насны хүүхдийн эндэгдэл 2013 онд 48 ба 1000 амьд төрөлтөд 17,38 промил, 2014 онд 66 болж ба 1000 амьд хүүхдэд 23,9 промил болж өссөн. - 0-5 насны хүүхдийн эндэгдэл 1990 онд 77,33 промил байсан ба 2013 онд 23,9 промил, 2014 оны 25.9 промил үзүүлэлттэй тус тус гарсан. Харин халдварт өвчин улс, аймгийн дундажаас доогуур үзүүлэлттэй байна. 	50%	
25		<p>5.1.2.3. Бүс нутгийн хөгжлийг татварын бодлогоор оновчтой дэмжинэ.</p> <p>1. Төвөөс алслагдсан, сул хөгжилтэй бүс нутгуудад жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг</p> <ul style="list-style-type: none"> - хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдах татвар төлөгчдийн тоо, хөнгөлсөн болон чөлөөлсөн татварын дүн <p>4. Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулахыг тус тус дэмжих</p> <ul style="list-style-type: none"> - Хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэх 		Татвар	<p>1. Төвөөс алслагдсан, сул хөгжилтэй бүс нутгийн хөнгөлөлт хэрэгжээгүй. Харин татварын бодолгыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан ба жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэдийг татварын бодлогоор дэмжиж, татварт хамруулах, гэрчилгээжүүлэх ажлыг тухай бүр зохион байгуулж ажилласан ба 2015 оны 01-р сарын 29-ны байдлаар татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх хүсэлтэй нийт 732 хүний 378.909 төгрөгийн буцаан олгох материалыг хүлээн аваад байна.</p> <p>4. Тус аймгийн Цагааннуур тосгонд Улаанбайшинтын олон улсын авто замын шалган нэвтрүүлэх боомт үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа бөгөөд цаашид өргөжиж худалдааны чөлөөт бүс болох зорилт тавигдсан. Одоогоор Цагааннуурын төвд худалдаа</p>	70%	30%

						үйлчилгээ хийх чөлөөт бүсийн хашаа баригдсан байгаа. Мөн Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайд Ш.Алтангэрэл ОХУ-д чөлөөт худалдааны бүс байгуулахыг санал хүргүүлсэн байгаа.			
26		<p>5.1.6.1. Экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг зохистой өсгөнө</p> <p>1. Эрдсийн болон мал аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортыг үе шаттай бууруулж, эцсийн бэлэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх.</p> <ul style="list-style-type: none"> - Эрдэс бүтээгдэхүүн болон мал аж ахуйн түүхий эдийн экспортод эзлэх хувь багассан байх, уул уурхайн болон хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрүүдийг ашиглалтад оруулсан байх <p>2. Оюуны шингэц бүхий бага оврын бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортыг өсгөх</p> <ul style="list-style-type: none"> - Үйлчилгээний худалдаа болон нэмүү өртөг шингэсэн, технологийн агууламжтай бүтээгдэхүүний эргэлт нэмэгдсэн байх 			ХБХ, ҮХАА Г	<p>1. 2014 онд Ногооннуур сумын Дулаан харын баяжуулах үйлдвэр ашиглалтан орж 404,0 тн гянтболдын, 700,0 тн цайрын баяжмал буюу нийт 7237,0 сая төгрөгийн бүтээгдэхүүн, 768,8 тн буюу 1621,2 сая төгрөгний угаасан ноос буюу нийт 8858,2 сая төгрөгний бүтээгдэхүүнийг тус тус экспортод гаргасан. Экспортын хэмжээ 2013 оноос 7438,1 сая төгрөгт хүсэн буюу 623,7%-иар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p>2. Казак үндэсний гар урлалаар бүтээсэн ширдэг, аравч, үндэсний хувцас, домбор хөгжим зэргийг БНКазахстан улс болон БНХАУ-ын ШУӨЗОронд экспортод гаргаж байгаа.</p>	100%	100%	
27		<p>5.1.6.2. Импортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг эдийн засгийн хөгжлийн хэтийн чиг хандлагатай оновчтой уялдуулан сайжруулна</p> <p>1. Импорт орлох зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих</p> <ul style="list-style-type: none"> - "Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх, ДНБ өссөн байх 			ХБХ, ҮХАА Г	2013 онд тус аймагт хөөсөнцөр, сэндвичэн хавтан, 2014 онд "Боржин" чулуугаар хавтан үйлдвэрлэж импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.	70%		
5.2.1. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого									
5.2.1.1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого									
28		<p>5.2.1.2. Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална.</p> <p>1. Уул, уурхайн ашиглалтад өртсөн талбайн нөхөн сэргээлтийг сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> - Нөхөн сэргээлт стандартын дагуу хийгдэнэ. <p>6. Уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалан гадаргын болон газрын доорх усны экосистем доройтох, бэлчээр хомсдох зэрэг сөрөг нөлөөллийг багасгахад анхаарч экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор гол мөрний эх, ай сав, ойн бүс, говийн баян бүрд, нуур цөөрөм, түүхийн дурсгалт газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохгүй байх, цаашид хэсэгчлэн хязгаарлах зорилгоор үе шаттай арга хэмжээ авч, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх эрх зүйн</p>			ХБХ, МХГ	<p>1. Газрын доройтлыг багасгах ажлын хүрээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтонд өртөж эзэнгүй орхигдсон нийт талбайгаас 1,2 га-д биологийн, 9,5 га-д техникийн нөхөн сэргээлт хийгдсэн.</p> <p>6. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль хэрэгжиж эхэлснээр гол мөрний эх, ай сав, ойн бүс, говийн баян бүрд, нуур цөөрөм бүхий газруудад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдохгүй байгаа. Сүүлийн 3 жилд томоохон орд газруудыг эзэмшиж буй байгууллагуудын үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хамтарсан үзлэг шалгалт явуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хамтарсан үүрэг даалгавар өгч, биелэлтэнд давхар хяналт тавьж ажилласан.</p>	70%	70%	

		орчинг боловсронгуй болгох - Эрх зүйн орчин бүрдсэн байна				Үүний үр дүнд газар, ус ашиглах, орд газрын нөхөн сэргээлт, сумын Засаг даргатай хийх гэрээнүүд болон сум орон нутагт төлөх төлбөрийн талаар гардаг зөрчил харьцангуй багасч байна.				
5.2.1.2 Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн бодлого										
29		<p>5.2.1.2.1. Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ</p> <p>1. Экспортын баримжаатай, оюуны шингэц бүхий өрсөлдөх чадвартай, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Экспортын баримжаатай оюуны багтаамж бүхий үйлдвэрүүдийн тооны өсөлт <p>2. Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд өрсөлдөх</p> <ul style="list-style-type: none"> - Экспортын бүтээгдэхүүний өсөлтийн хувь - Эко бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ <p>3. Оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн тооны өсөлт <p>6. Өөрийн оронд үйлдвэрлэх боломжтой хүнсний болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг хөгжүүлж, импортоос хэт хараат байдлыг багасгах</p> <ul style="list-style-type: none"> - Үйлвэрлэлийн өсөлтийн хувь, дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хангалтын хувь 			ХБХ, ҮХАА Г	<p>1. Экспортын баримжаатай, оюуны шингэц бүхий өрсөлдөх чадвартай, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. Одоогоор тус аймагт шинээр байгуулагдсан Боржин чулууны үйлдвэр, цементийн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнээр орон нутгаа хангахын зэрэгцээ экспортод гаргах бодлоготой байна. Үйлдвэрлэсэн боржин чулуун хавтангаар аймгийн ЗДТГ-ын гаднах үүднээс эхлэн төв талбай хүртэл битүү хучих ажил 2014 онд эхэлсэн ба ажлын гүйцэтгэл 2015 оны 2-р улиралд бүрэн хэрэгжиж дуусна.</p> <p>2. Тус аймгаас экспортод экологийн цэвэр бүтээгдэхүүн болох малын мах, ноос ноолуур, барагшууны баас, Хар тугалга, цайр, гянт болдын баяжмал үйлдвэрлэж экспортолж байна. 2013 онд 291 тн барагшуун, 231,6 тн хонины ноос, 81,4 тн тэмээний ноос гаргаж 1379,5 сая төгрөгийн бүтээгдэхүүн экспортолсон бол 2014 онд Хонины угаасан ноос 396,2 тн Хар тугалга, цайрын баяжмал 700 тн, гянт болдын баяжмал 287.4 тн үйлдвэрлэж 6985.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортолж өнгөрсөн оноос экспортолсон бүтээгдэхүүний хэмжээ 5 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p> <p>3. “Аватекс–Хайнар-Ноос” ХК жилд 396,2 тн хонины ноос угаан, самнаж, Англи, Герман улсад экспортолж 1,5 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. Оёмол, хатгамалын чиглэлээр 61 жижиг цехүүд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үндэсний хатгамал бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэдэг “Казах крафт” ХХК нь 18 төрлийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ Казахстан, БНХАУ-д экспортлож 60 сая төгрөгийн борлуулалт хийжээ.</p> <p>6. Махны хэрэгцээг 100%, төмсний хэрэгцээний 61,5%, хүнсний ногооны хэрэгцээний 19,4 %-ийг дотоодын бүтээгдэхүүнээр хангаж байна.</p>	70%	100%	100%	70%

5.2.1.3. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийн бодлого							
30		<p>5.2.1.3.2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно.</p> <p>1. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник, технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах, шалгаруулах явцад нь зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төвүүдийг аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд зохион байгуулж ажиллуулах</p> <ul style="list-style-type: none"> - Аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд ажиллаж буй төвүүдийн тооны өсөлт <p>2. Жижиг, дунд үйлдвэрлэлийн бодлогын асуудалтай холбоо бүхий аливаа шийдвэрийг гаргахдаа тэдний ашиг сонирхлыг илэрхийлэгч мэргэжлийн холбоодын саналыг авч тусгаж байх</p> <ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн холбоод болон ТББ-тай хамтран шийдвэрлэсэн асуудал <p>3. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бизнес инкубатор байгуулж ажиллуулах</p> <ul style="list-style-type: none"> - Шинээр байгуулагдсан бизнес инкубаторын тоо <p>4. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдож байгаа тусгай зөвшөөрлийг цахим үйлчилгээнд бүрэн шилжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Үйл ажиллагааны хэрэгжилт 		<p>НХХ, ХөдХ</p>	<p>1. 2014 оны 3 –р сарын 19-ний өдөр “ЖДҮ эрхлэгч нарын зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан ба үүнд 13 сумын нийт 250 төлөөлөгч оролцов. Уг зөвлөгөөний үеэр ЖДҮ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Мөн сумын төлөөлөгч нар Ховд аймагт зохион байгуулагдсан ЖДҮйлдвэрүүдтэй танилцах, харилцан туршлага солилцох зорилгоор 2 өдрийн аялалыг зохион байгуулав. 2014 оны 06-р сарын 04-ний өдөр Хөдөлмөрийн хэлтэс, аймгийн ЗДТГ, аймгийн хоршоодын холбоо, аймгийн худалдаа эд эрхлэгчдийн хоршооны холбоотой хамтарч 65 хоршоо, ахуйн үйлчилгээ эрхлэгчдэд “Хоршоо, ахуй үйлчилгээ эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан ба орон нутгийн радиогоор ЖДҮ талаарх мэдээллийг 5 удаа, “MNB”, “НАЗ”, “Дербес” телевизээр дамжуулан ЖДҮ-ийн зээл, зээлийн батлан даалтын сан болон бусад мэдээллийг хүргүүлсэн.</p> <p>2. ЖДҮХСангийн хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах комиссын гишүүнд аймгийн ҮЭХолбоо, ажил олгогч эздийн холбоо, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим /МХАҮТ/-ын аймаг дахь салбар, Аймгийн барилгачдын холбоотой хамтран ажиллаж, ЖДҮ эрхлэгчдийн төслүүдийг сонгон шалгаруулав. Мөн аймгийн хөдөлмөрийн хэлтэс, Ажил олгогч эздийн холбоо, ҮЭХолбоо болон “Дэлхийн Зөн” ОУБайгууллагатай хамтран “ЖДҮ эрхлэгч нарын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, ЖДҮ эрхлэгчдийн тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлагыг тодорхойлж, зөвлөгөөний төгсгөлд зөвлөмж боловсруулан гаргасан.</p> <p>3. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бизнесийн “Мендалика” инкубатор төв байгаа ба уг төв нь жижиг зээл, ажлын байран дахь болон шавь сургалтыг өргөтгөх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж байна. Мөн жижиг, дунд үйлдвэрлэлийн тусгай бүс байгуулах талаар судалгааг боловсруулан ажиллахын зэрэгцээ энэ чиглэлийн холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын тогтоолтой танилцаж, өөрийн аймгийн онцлогт тохирсон боломжит суурь давуу талыг судалж, ажил хэрэг болгож байна.</p>	<p>90%</p> <p>70%</p> <p>50%</p>	

						4. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдож байгаа тусгай зөвшөөрлийг цахим үйлчилгээнд шилжүүлэх үйл ажиллагаа хэрэгжиж эхэлсэн.	30%				
5.2.1.4. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого											
31		<p>5.2.1.4.1. Бүс нутгийн онцлогийг харгалзан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, халдварт өвчний гаралт, тархалтыг эрс бууруулан малыг эрүүлжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, экспортыг нэмэгдүүлнэ.</p> <p>1. Малыг халдварт болон шимэгчит өвчнөөс хамгаалах өндөр технологийг нэвтрүүлж эхлэх</p> <ul style="list-style-type: none"> - Үйлдвэрийн тоног төхөөрөмж болон технологи шинэчлэгдэж био аюулгүй байдлын түвшин дээшилсэн байна - Монгол малын тэсвэрт чанарыг бататган, цус ойртохоос урьдчилан сэргийлж, биологийн боломжийг бүрэн ашиглаж, байгалийн эрсдэл даах чадварыг нь бэхжүүлэх - Цөм сүргийн малын тооны өсөлт. малын чанар, үржлийн ажлыг сайжруулах - Малыг гаралтай бүтээгдэхүүний өсөлтийн хувь <p>4. Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэн мал аж ахуйн эрсдэлийг бууруулах</p> <ul style="list-style-type: none"> - Бэлчээрийг зохистой ашиглаж сайжруулсан талбайн хэмжээ <p>5. Биотехнологийн ололтыг нэвтрүүлж, мал үржүүлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Мал үржүүлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт <p>7. Малчдыг хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх болон мал аж ахуй эрхлэх арга ухааны чиглэлээр малчдын дунд албан бус сургалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Малчдын хамтран үйлдвэрлэл эрхлэх бүтэц, хэлбэрийн оновчтой загвар бий болсон байх - Албан бус сургалтад хамрагдсан болон мэргэшсэн малчны тоо - Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг 			ХБХ, ҮХАА Г	<p>1.1. Малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 12 төрлийн вакцины /ОХУ-аас шүлхийн вакцин/ 11-ийг У-Б хотын Био үйлдвэрээс, Паразит өвчний эмчилгээнд Англи, Энэтхэг, Канад, Хятад, Орос улсад үйлдвэрлэгдсэн чанарын баталгаат эмээр хангаж байгаа.</p> <p>1.2. Монгол малын тэсвэрт чанарыг бататган, цус ойртохоос урьдчилан сэргийлж, 2014 онд сумын МЭҮТ, мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдийн оролцоотойгоор 241 тэмээ, 2394 адуу, 3896 үхэр, 25595 хонь, 21477 ямаа, бүгд 53603 толгой малд ашиг шимийн ангилалт, хээлтүүлэгч малын үзлэг, хянан баталгааг явуулж, аймгийн хэмжээгээр сум орон нутгийн чанартай 426 цөм сүргийг бий болгож тухайн сумын Засаг даргын захирамж гаргуулан, малчдад шилмэл нэгдүгээр ангийн малыг үржилд байнга ашиглах талаар гэрээ байгуулан, гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулсан.</p> <p>1.3. Хээлтүүлэгч малыг жил бүр хянан баталгаажуулалтанд хамруулдаг, Сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сангаас малын чанарыг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуй байгуулах талаар хөрөнгө хуваарилах тухай зөвлөмжийг сум бүрт хүргүүлсэн. Үүнээс Сагсай сум 7,0 сая төгрөг хуваарилж, Дэлүүн сумын “Керей” үүлдрийн хонины цөм сүргээс 25 хурган хуц, Цэнгэл сумын “Жыланды” МЭҮН мөн Дэлүүн сумаас 40 хурган хуц, Улаанхус сум Баяннуур сумаас “Уулын бор” үүлдрийн 27 ухна, Дэлүүн сумаас “Керей” үүлдрийн 37 хурган хуцыг үржилд зориулан худалдан авсан ба МАА-н хэлтсээс гэрээ байгуулах, захиалга өгөх ажиллагаанд зуучилж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</p> <p>4. Малчид бэлчээрээ зун, намар, өвлийн улиралд сэлгэн зүй зохистой ашиглаж байгаа ба 2014 онд өвсний ургац сайн байсан.</p> <p>5. 2012 онд 125 үнээнд, 2013 онд 86 үнээнд зохиомол хээлтүүлэг хийгдсэн. Аймгийн төвийн Өлгий сумд бод малын зохиомол хээлтүүлэг хийх техникч ажиллуулж, үржлийн үйлчилгээний нэгж нэгийг байгуулан зохиомол</p>	90%	100%	100	70%	10%

		батлуулж хэрэгжүүлэх эхний үе шатны төлөвлөгөөг Засгийн газраар батлуулсан байх			<p>хээлтүүлгийн багаж хэрэгсэл, үр, азот, ороо идэвхжүүлэгч эм урвалж худалдан авах, үржлийн бухтай болох зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлэх, зохиомол хээлтүүлгийн төвийг багаж хэрэгсэлтэй, эргэлтийн сантай болгоход дэмжлэг үзүүлэхийг хүсэж МУСҮТ, аймгийн ИТХ болон Засаг даргад төсөл боловсруулан оруулсан боловч дэмжлэг аваагүй. Энэхүү байдлаас шалтгаалан үхрийн зохиомол хээлтүүлгийн ажил 2014 онд хийгдээгүй болно.</p> <p>7. Малчдын хамтран үйлдвэрлэл эрхлэх бүтэцийн оновчтой хэлбэр нь Фермерийн аж ахуй эрхлэх, малчдын дунд малчдын хоршоо байгуулах явдал чухал байр суурь эзэлдэг. Энэ ч үүднээс хоршооны тухай сургалтуудыг бүх сумдын 833 малчдад зохион байгуулсан. Аймгийн хэмжээнд нийт 18195 малчдад мэргэжлийн үнэмлэх, тамга тэмдэг олгогдсон. Мөн Хоршооны нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж хоршоологчид болон шинээр хоршоо байгуулах хүмүүст хоршооны шинэчилсэн дүрэм, хоршооны тухай хуулийг олшруулан өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө болон малчдын бүлэг байгуулахад туслах гарын авлага номыг сурталчилан тарааж өгөхийн хамт орон нутгийн “Наз” телевизээр ард иргэдэд хоршооллын талаар сурталчилгаа явуулсан. Үүний үр дүнд шинээр 34 малчдын хоршоо бий болж, ажлын байрны тоо 136-аар нэмэгдсэн.</p>	70	
32		<p>5.2.1.4.2. Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг хөгжүүлэн, биотехнологи нэвтрүүлэн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ</p> <p>2. Эрчимжсэн газар тариалан эрхэлж буй хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагыг төсөв, татварын бодлогоор дэмжих</p> <ul style="list-style-type: none"> - Эрчимжсэн газар тариалан эрхэлж буй хувь хүн, аж ахуйн нэгжийн өсөлт, аж ахуйн нэгж, иргэдийн орлогын өсөлт <p>3. Услалтын оновчтой системийг бий болгон усалгаатай газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг лизингээр олгох, усжуулалтын барилга байгууламжийн эзэмшилт, ашиглалтыг зах зээлийн зарчимд нийцүүлж сайжруулах</p>		ХБХ, ҮХАА Г	<p>2. Эрчимжсэн газар тариаланг 2013 онд 278 иргэн 5.9 га талбайд тариалалт хийж 57.9 тн ургац хураан авсан. 2014 онд 280 өрх 6.2 га талбайд тариалалт хийж 65.5 тн ургац хураан авсан.</p> <p>3. Услалтын оновчтой системийг бий болгон усалгаатай газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг лизингээр авах иргэн, аж ахуйн нэгж гараагүй. Усжуулалтын барилга байгууламжийн эзэмшилтийн талаар: Алтай сумын Тилекийн “Шаргуу”, Алтанцөгцийн ЗДТГ-ын “Хар үзүүр”, Баяннуур сумын “Цул улаан” Азык ХХК-ний захирал Жалелийн, Булган сумын Тауба” ХХК-ны “Хужирт”, Цагаан эрэг”, Буянт сумын ЗДТГ “Мандах”, “Мурап” ХХК-ны Халиасхарын, Дэлүүний “Дэгээ хар” Толбо сумын “Шүмек”, Улаанхусын “Жалангаш”, Цэнгэлийн “Харгант” зэрэг 12</p>	70%	70%

		<p>- Нэгж талбайгаас авах ургацын өсөлт</p> <p>4. Богино хугацаанд түргэн боловсордог чанартай үрийг өргөн хэрэглэж, таримал ургамлын нэр төрлийг олшруулах</p> <p>- Үр үржүүлгийн төвүүд бий болсон байна</p> <p>5. Өрхийн аж ахуйн үйл ажиллагааг хөнгөвчлөх орчин үеийн бага оврын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг импортолдог болон дотооддоо үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжийг дэмжих</p> <p>- Бага оврын техник, тоног төхөөрөмжийн хангалтын тоо</p> <p>6. Жимс, жимсний мод үржүүлгийн газруудыг байгуулж, жимс, жимсгэний тариалалтыг өргөтгөх</p> <p>- Дотоодод үйлдвэрлэсэн жимс жимсгэний хангамжийн өсөлт</p> <p>7. Таримал ургамлын өвчин, хортонтой тэмцэх, сорт, сорилтын чанарыг сайжруулж, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх</p> <p>- Таримал ургамлын нэр төрлийн өсөлт, нэгж талбайгаас авах ургацын хэмжээний нэмэгдэл</p>			<p>услалтын системүүд ЗДТГ-ын мэдэлд орсон. Цэнгэлийн “Шар нуур”, “Малчны хөгжил” хоршооны Ахайн, “Хара татыр” “Еликт” хоршооны Ерболатын мэдэлд, Хадлангийн “Цэнгэл ирээдүй” ХХК-ны Асхарын, Өлгий сумын “Их булан, “Алатау” ХХК-ны Маягийн, Ногооннуур сумын “Бөх мөрөн, “Ачит алхабы” ХХК-ны эзэмшилт байна. Эдгээр услалтын системүүдийн ашиглалт одоогоор сайжраагүй, цаашид хэвийн ажиллуулахад шаардлагатай бүхий л арга хэмжээ авахаар төлөвлөж байна.</p> <p>4. Тус аймагт дулааны үргэлжлэх хугацаа бага учраас богино болцтой бөөрөнхий сонгино, бөөрөнхий байцаа, шар лувангийн Белорусская-85 сорт, өргөстийн хэмхийн 60-90 хоногийн болцтой хятадын үр, улаан лоолийн, урт сонгино, шар манжин, төмсний Санте, Гала, Импала, Витара зэрэг эрт болцтой үрүүдийг ҮХААЯ болон Монголын тариаланчдын холбоонд захиалга өгч, хуваарилсан үрүүдийг татан авч, тариалалт хийсэн. Аймгийн хэмжээнд 20-25 нэр төрлийн таримлыг тариалдаг бөгөөд үр үржүүлгийг тариаланчид өөрсдөө хийж гүйцэтгэдэг</p> <p>5. 2014 онд тус аймагт байгаа 30 ш бага оврын тракторд хуваарилагдсан. Гэсэн хэдий ч тариаланчид хөрөнгө мөнгөний дутагдлаас болж зөвхөн Ногооннуур сумын 6 тариаланч бага оврын тарктор авахаар захиалгаа өгсөн.</p> <p>6. Жимс, жимсгэний суулгац, үржүүлэх чиглэлээр чацарганы суулгацыг аймгийн ойн аж ахуйн анги 6500 ширхэг, 165 дугаар цэргийн анги 1500 ширхэгийг бэлтгэж байна. 2014 оны байдлаар бүгд 41 аж ахуйн нэгж, иргэн оролцож бүгд 48390 ширхэг чацарганы суулгац авч 38,7 га-д тариалалт хийсэн. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд хувиараа болон ОНХС-гаас чацаргааны суулгацыг худалдан авч тариалж, 2014 оны байдлаар 74,1 га-д тариалалт явуулж, жимсгэний тариалалт жилээс жилд нэмэгдэж байна</p> <p>7. Таримал ургамлын өвчин хортонтой тэмцэх зорилгоор орон нутгийн төрөл бүрийн аргуудыг хэрэглэж байгаагаас гадна хөрс боловсруулалт болон намрын боловсруулалтыг цаг хугацаанд нь хийж, Децис, Раундап, Гармоксон зэрэг пестицидийн төрлийн хортон шавьж устгах бодисыг сүүлийн жилүүдэд өргөн хэрэглэж байна. Сайн чанарын үрээр тариалалт хийж, төмсний үрийг “Монгол төмс” хөтөлбөрийн хүрээнд 1</p>	<p>90%</p> <p>50%</p> <p>70%</p> <p>70%</p>	
--	--	---	--	--	---	---	--

					дүгээр продукцийн элит үрээр тариалалт хийж байна. Хүлэмжийн аж ахуйн талаар 2014 онд 288 ш зуны хүлэмж ашиглан 16770 м2 талбайд тариалалт хийсэн ба 88,8 тн ургац хураан авсан.		
33		<p>5.2.1.4.8. Хүнсний үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулна.</p> <p>1. Экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний болон импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Үйлдвэрлэсэн экологийн цэвэр хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ <p>2. Орчин үеийн техник, технологитой хүнсний үйлдвэрлэлийг хөгжүүлэн хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд, хүртээмжтэй хангаж, гадаад зах зээлд нийлүүлж эхлэх</p> <ul style="list-style-type: none"> - Хүнсний баталгаат байдал хөтөлбөрийн зорилтын хэрэгжилт <p>3. Тохиромжтой бүс нутгуудад бөөний худалдааны төв, бирж байгуулж, хүнсний бүтээгдэхүүний борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох</p> <ul style="list-style-type: none"> - Бөөний худалдааны биржийн тоо 		ХБХ, ҮХАА Г	<p>1. Монгол улсын ЭМСайдын 2008 оны 257 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан “Хүн амын хоол тэжээлийн физиологийн норм”-оор аймгийн хүн амын гол нэрийн 13 төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг тооцож, сумдад хүргүүлж, нормыг мөрдлөг болгон ажилласан. Үүний үр дүнд аймгийн хүн амын хэрэгцээт махыг бүрэн, төмсний 63,4 хувь, хүнсний ногооны 20,7 хувь, жимс жимсгэний 1,0 хувь, гурилан бүтээгдэхүүний 2 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна.</p> <p>2. 2014 онд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний 220 цэг салбар, 33 бар шөнийн клубт хяналт шалгалт хийгдэж 33 үйлчилгээний газрыг хааж, 12 баарыг түтгэлзүүлсэн. Бүх төрлийн малын гаралтай сүүг 9 үзүүлэлтээр богино хугацаанд шинжлэн дүгнэлт гаргах Milkscan багаж хэрэгслийг МЭАЦ-ийн лабораторид суурилуулсан.</p> <p>3. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 32 дугаар тогтоолоор аймгийн “Бөөний худалдааны хөтөлбөр” батлуулан мөрдөж ажиллаж байгаа ба зохион байгуулах салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг байгуулсан. Аймгийн төвийн худалдаа үйлчилгээ эрхэлдэг 13 ААН-ийг худалдааны сүлжээ байгууллагаар тодорхойлсон.</p>	70%	
34		<p>5.2.1.4.4. Газар тариалангийн болон бэлчээрийн усанхангамжийг сайжруулж, хөдөөгийн хүн амын ундны усны хэрэгцээ, шаардлагад тохирсон усны нөөцийг нэмэгдүүлнэ.</p> <p>1. Ашиглагдахгүй байгаа бэлчээрийг худаг гаргаж, хурын ус хуримтлуулж, булаг шандны усыг нэмэгдүүлж, усжуулах Малын усан хангамжийн өсөлтийн хувь</p>		ХБХ, ҮХАА Г	<p>1. 2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 18 худгийг шинээр гаргаж ашиглалтан оруулсан</p> <p>2. Жил бүр бэлчээрийн усан хангамж, мал, малчдын ундны усны зориулалтаар улсын төсвийн хөрөнгөөр 18-аас доошгүй худаг гаргаж сумын ЗДТГ болон малчдад гэрээгээр эзэмшүүлж байгаа. Аймгийн хэмжээнд 2014 онд 195 худгийг ундны болон мал услах</p>	70%	90%

		<ul style="list-style-type: none"> - Хур борооны усыг хуримтлуулж байгуулсан хөв цөөрмийн тоо 2. Малчдын ундны усны хүрэлцээг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах - Худгийн тоо 3. Зарим голын усны урсацын тохируулга хийж бороо, цасны усыг хуримтлуулан гантай, хуурай үед ус хэрэглэх зориулалттай гидротехникийн байгууламжуудыг бий болгох - Шинээр байгуулагдсан зориулалтын гидротехникийн байгууламжийн тоо - Хуримтлуулсан усны хэмжээ /мян.шооометр/ 				<p>зориулалтаар ашиглаж байна.</p> <p>3. Орон нутгийн иргэдийн зүгээс хуурай үед ус хэрэглэх зориулалттай гидротехникийн байгууламж зайлшгүй байгуулах шаардлагагүй гэсэн санал хүсэлт гаргасан. Гэсэн хэдий малчид тариланчид орон нутгийн онцлог, болон байгальд хоргүй уламжлалт аргуудаар малын усан хангамжийн асуудлыг бүрэн шийдвэрлэж байгаа.</p>	30%	
35		<p>5.2.1.4.5. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.</p> <p>1. “Тэжээл” хөтөлбөр хэрэгжүүлж, малын тэжээл, усны хангамжийг сайжруулах</p> <ul style="list-style-type: none"> - Малын тэжээлийн үйлдвэрлэлийн өсөлт <p>2. Малын тэжээлийн үйлдвэрлэл, нийлүүлэлт, хэрэглээний эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, төрийн бодлогоор дэмжих</p> <ul style="list-style-type: none"> - Тэжээлийн үйлдвэрийн тоо, үйлдвэрлэсэн тэжээлийн хэмжээ <p>3. Шимт чанар сайтай, ургац ихтэй тэжээлийн шинэ төрлийн таримал нутагшуулах, үр үйлдвэрлэлийг дэмжиж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, фермерийн аж ахуйг тэжээлийн ургамлын үрээр хангах тогтолцоо бүрдүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Үр үйлдвэрлэх аж ахуйн нэгжийн тоо тэжээлийн ургамал тариалсан талбайн хэмжээ <p>4. Бэлчээрийн мал аж ахуйн эрсдэл даах чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор жилийн тодорхой хугацаанд малаа тэжээдэг малчдын арга ажиллагааг дэмжин хөгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Бэлчээр хадлангийн талбайг хамгаалах, сайжруулах хадлан тэжээл бэлтгэх чиглэлээр дэмжлэг авсан иргэд, аж ахуйн нэгжийн тоо 			ХБХ, ҮХАА Г	<p>1. 2014 оны мэдээгээр 3167 га бэлчээр, хадлангийн талбайг хашиж хамгаалсан. Хашиж хамгаалсан талбайг услах шуудуу татах, гар худаг гаргах ажлыг малчид, мал бүхий иргэд санаачлан хийж байна. Тус аймагт өвөлжилтийн бэлтгэл хангалт 92,0 хувьтай гарсан ба тэжээл хангамж 186,1%, усан хангамж 92,3%, хашааны хангамж 113,8%, давс хужирын хангамж 94,9%, -тай байна.</p> <p>2. 2014 онд байгалийн хадлан 62373,6 тн, гар тэжээл 5760 кг бэлтгэж, 1453,9 тн малын тэжээл хураан авсан ба орон нутагт үйдвэрийн аргаар 65,0 тн малын тэжээл үйлдвэрлэж бэлтгэсэн.</p> <p>3. 2014 оны байдлаар 500 кг овъёосны үр, 500 кг хөх тариа, 500 кг царгас, согооврын үрийг аж ахуйн нэгж байгууллагын захиалгаар татан авч нийлүүлсэн. Тариалах, арчлах аргын талаар мэргэжлийн зөвлөгөө, арга зүйгээр хангаж ажилласан. Харин тарималын үр үйлдвэрлэж буй аж ахуйн нэгж байхгүй байна.</p> <p>4. Хадлангийн талбай шинээр нээх, газар тариалан эрхлэх, хашиж хамгаалах чиглэлээр 40 аж ахуйн нэгж болон иргэдэд ОНХсангаас 322,2 сая төгрөг, 8 иргэн аж ахуйн нэгж хадлангийн талбайг усжуулах, суваг шуудуу татах чиглэлээр 87,5 сая төгрөгний дэмжлэг авч ажил хэрэг болгосон.</p>	70% 90% 70% 100%	
36		<p>5.2.1.4.6. Хөрсийг эвдрэлээс хамгаалах, үржил шимийг хадгалах, чийгийн ууршилтыг багасгахад чиглэсэн дэвшилтэт технологийг газар тариаланд нэвтрүүлнэ.</p> <p>1. Химийн аргаар боловсруулах уриншийн хэмжээг нэмэгдүүлэх</p>				<p>1 болон 2-р арга хэмжээ: Аж ахуйн нэгжүүд багахан хэмжээний буюу 45 га-д үр тариа тариалдаг. Манай аймаг газар өндөр уулын бүсэд харьяалагддаг тул бүс нутгийн онцлогоос хамаарч уринш бэлтгэх аргыг нэвтрүүлээгүй. Харин хавар үрсэлгээний болон чийг ууршилтыг барих зорилгоор тариаланчид нийлэг</p>	50%	

